



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Төслийн үйл ажиллагааны 2019 оны жилийн тайлан

Улаанбаатар хот
2020.01.10



Товчилсон үгийн жагсаалт

АБОУ	Анхдагч байгаль орчны үнэлгээ
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БОМТ	Байгаль орчны менежмент төлөвлөгөө
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
БОННУ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
БУА	Барилга угсралтын ажил
ГМТХ	Газрын мэдээллийн технологийн хэлтэс
ГЧНШ	Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт
ГЧХ	Газар чөлөөлөх хэлтэс
ЕХОБ	Европын Хөрөнгө Оруулалтын Банк
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МХС	Мэдээлэл Холбооны Сүлжээ ТӨХК
НАЗХГ	Нийслэлийн Авто зам хөгжлийн газар
НГА	Нийслэлийн Газрын алба
НГЗБА	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
НОБГ	Нийслэлийн Онцгой байдлын газар
НОСК	Нийслэлийн Орон сууцны корпораци ХК
НӨАУГ	Нийслэлийн Өмч ашиглалт, удирдлагын газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НХТЕТГ	Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар
НХОГ	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ
НХБХГ	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар
ОСЗ	Оршин суугчдын зөвлөл
УСУГ	Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ
СААХ	Санхүү, аж ахуйн хэлтэс
СБД	Сүхбаатар дүүрэг
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЯ	Сангийн Яам
ТУН	Төслийн удирдах нэгж
ТББ	Төрийн бус байгууллага
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
УБДС	Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК
УБЦТС	Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК
УИХ	Улсын Их Хурал
УБХЗ	Улаанбаатар хотын захиргаа
УДДТ	Ус дулаан дамжуулах төв
ҮХС	Үерийн хамгаалалтын суваг
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХБББ	Хамгааллын бодлогын баримт бичиг
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
ХБОБНУГ	Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газар
ХСГ	Хөгжлийн санхүүжилтийн газар
ХДС	Хамгаалалтын далан суваг
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭХЯ	Эрчим Хүчний Яам



Тайлангийн агуулга

I. Төслийн товч танилцуулга	4
II. Төслийн үйл ажиллагаа ба үр дүн	6
III. Хөтөлбөрийн I үе шат - Баянхошуу, Сэлбэ дэд төв	8
Бүрэлдэхүүн 1. Авто зам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх	8
➤ Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаа	9
➤ Худалдан авах ажиллагаа	12
➤ Барилга угсралтын ажлууд	14
Бүрэлдэхүүн 2. Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд барих	33
➤ Баянхошуу дэд төвд барих нийгмийн барилга байгууламжууд	33
➤ Сэлбэ дэд төвд барих нийгмийн барилга байгууламжууд	35
Бүрэлдэхүүн 3. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын менежментийг бэхжүүлэх	37
➤ Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, барилга угсралтын хяналтын үйлчилгээ	37
➤ Хот төлөвлөлтийг сайжруулах, дэд төвийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээ	38
➤ Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг чадавхжуулах	40
➤ УСУГ-ыг дэмжих үйл ажиллагаа	40
Бүрэлдэхүүн 4. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын менежментийг бэхжүүлэх	43
➤ Төслийн удирдлагын дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	43
➤ Иргэд, олон нийтийн оролцоог хангах болон ЖДҮ-ийг хөгжүүлэх	44
➤ АХБ-ны Хамгааллын бодлогыг хэрэгжүүлсэн байдал	51
➤ Төслийн санхүүгийн менежмент	53
➤ Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал	55
IV. Хөтөлбөрийн II үе шат – Дамбадаржаа, Дэнжийн Мянга дэд төв	57
V. Дүгнэлт, тулгамждаж буй асуудлууд	60
Хавсралт 1. Хүлээлгэн өгсөн барилга угсралтын ажлууд	61
Хавсралт 2. Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн өнөөгийн байдал	64
Хавсралт 3. Жендэрийн болон нийгмийн үйл ажиллагааны матриц /АХБ-ид тайлагнадаг загвараар/	72
Хавсралт 4. Төслийн хүрээнд зохион байгуулсан сургалт, оролцогчдын мэдээлэл	81

I. Төслийн товч танилцуулга

Санхүүжилтийн эх үүсвэр:	(i) Азийн хөгжлийн банк (АХБ)-ны хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж; (ii) Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ)-ны хөнгөлөлттэй зээл; (iii) МУЗГ - Нийслэлийн Засаг даргын Тамгын Газрын Хөрөнгө оруулалт;	
Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:	Нийслэлийн Засаг даргын Тамгын Газар, Төсөл хэрэгжүүлэх нэгж	
Төслийн төсөвт өртөг:	Үе шат-1 АХБ-наас 19.78 сая ам.долларын зээлжих тусгай эрх бүхий зээл, 27.5 сая ам.долларын ердийн эх үүсвэрийн хөнгөлөлттэй зээл, 3.7 сая ам.долларын буцалтгүй тусламж. ЕХОБ-наас 22.01 сая долларын зээл. Монгол улсын Засгийн газраас 33.15 сая ам доллар. Нийт 106.14 сая ам доллар.	Үе шат-2 АХБ-наас 29.24 сая ам.долларын зээлжих тусгай эрх бүхий зээл, 37.11 сая ам.долларын ердийн эх үүсвэрийн хөнгөлөлттэй зээл. ЕХОБ-наас 19.64 сая еврогийн зээл. Монгол улсын Засгийн газраас 35.15 сая ам доллар. Нийт 121.14 сая ам доллар.
Төслийн хугацаа:	I Үе шат: 2014.09.24 – 2021.06.30	II Үе шат: 2017.03.14 – 2022.02.28
Төслийн явц:	I Үе шат: 74.27 хувь	II Үе шат: 12.76 хувь

Төслийн үндэслэл

Улаанбаатар хотын нийт хүн ам 2018 оны байдлаар 1.5 саяд хүрч, гэр хороололд шилжин суурьшсан иргэдийн тоо улам бүр нэмэгдсээр байна. 2025 он гэхэд хүн амын тоо 1.8 саяд хүрч, хүн амын ердийн өсөлтөөр 400.000 орчим хүн амаар өсөх тооцоо байна. Өнөөгийн хотын амьдрах орчин, нөхцөлийг сайжруулахгүй бол хүн амын өсөлтийн улмаас хотын хүн амын эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд ноцтой аюул учруулж болзошгүй. 2018 оны байдлаар гэр хороололд амьдарч буй хүн ам нийт 786.825 буюу Улаанбаатар хотын хүн амын 54.5%, улсын нийт хүн амын 25%-ийг тус тус эзэлж байна.

Иймд, Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хот болгон зохисгүй төвлөрлийг сааруулж, нийгмийн болон хотын үйлчилгээг жигд хүртээмжтэй болгох зайлшгүй шаардлагатай. Үүний тулд хотын хойд болон баруун бүсийн хүн амд үйлчилдэг худалдаа, соёлын үйлчилгээний төвлөрөл бүхий байгаль орчинд ээлтэй ногоон орчныг бүрдүүлсэн дүүрэг бүсийн чанартай дэд төвүүдийг бий болгохоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” бодлогын баримт бичигт тусгасан. Тус баримт бичгийг хэрэгжүүлэхээр эдийн засгийн боломж, орон сууц, хотын дэд бүтцийн үйлчилгээ хангамж бүхий эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн, бие даан хөгжсөн дэд төвийн сүлжээг гэр хороололд бий болгох зорилт дэвшүүлэн “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Уг хөтөлбөрийг санхүүжүүлэх Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг МУ-ын УИХ-аар 2014 оны 05 дугаар сарын 23-ны өдөр соёрхон баталсан.



Төслийн зорилго: Нийт 9 жилийн хугацаанд 3 үе шаттай хэрэгжих энэхүү хөтөлбөр нь Улаанбаатар хотын гэр хорооллыг иргэдийн оролцоотой дахин төлөвлөх, усан хангамж, цэвэрлэх байгууламж, дулааны үйлчилгээг нэмэгдүүлэх, нийгэм эдийн засгийн дэд бүтцийг сайжруулж, бичил санхүүжилтийг дэмжих, төсөл хэрэгжүүлэгч байгууллагыг чадавхжуулах зорилготой бөгөөд хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын бүсэд 6 дэд төв шинээр байгуулах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

Нийгэм, эдийн засгийн үр ашиг:

- Хотын төвөөс гадагш чиглэх бараа материалын урсгал, хүн амын хөдөлгөөнийг хялбар болгох, хотын хөгжлийн шинэ тэнхлэг үүсгэх бие даасан дэд төвүүд бий болгох зорилгоор гэр хорооллын дэд бүтцийн системийг сайжруулна. Хот төлөвлөлтийг сайжруулан дэд бүтцийн шугам сүлжээг авто замтай хослуулан хийснээр гэр хорооллын бүсийн хэв маяг, бүтцийн өөрчилж, хот байгуулалтын явцыг зохистой болгох боломжийг бий болгоно.
- Инженерийн дэд бүтцээр бүрэн хангагдсанаар дэд төвийн иргэд газраа хувь нийлүүлэн төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах замаар орон сууцны нөхцөлөө сайжруулах боломжтой болно.
- Төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангасан түншлэлийн оновчтой хэлбэр бий болж газрыг зөв, дахин зохион байгуулж, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг зохицуулах оновчтой механизм бүрдэнэ.
- Хууль эрх зүйн орчны шинэчлэлийг давхар хийснээр дэд төвд бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.



Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл арга хэмжээ

Санхүүжилтийн Ерөнхий Хэлэлцээрт заасны дагуу АХБ-ны Худалдан авах ажиллагааны журам, Хамгааллын бодлогын баримт бичиг болон АХБ-ны холбогдох журмуудыг баримтлан ажилладаг.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 108 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/551 тоот захирамжаар “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулж, бүтэц, орон тоог /11 ажилтан/ баталсан.


Монгол Улсын Сангийн сайдын 2019 оны 72 тоот тушаалаар “Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог шинэчлэн, нийт 23 ажилтантай ажиллаж байна.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 107 тоот тогтоолоор Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг анх баталсан бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/586 тоот захирамжаар Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, Төслийн удирдах хорооны даргаар Нийслэлийн Засаг дарга ажиллаж байна.

II. Төслийн үйл ажиллагаа ба үр дүн

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаа нь 2014 оны 05 дугаар сарын 23-ны өдөр МУ-ын УИХ-аар соёрхон баталсан МУ-ын Засгийн газар болон Азийн Хөгжлийн Банк хооронд 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн Ерөнхий Хэлэлцээр (СЕХ)-ээр тодорхойлсон хүрээнд хязгаарлагдана.

Төслийн үндсэн үйл ажиллагааны бүдүүвч



Тайлбар: Төслийн үндсэн үйл ажиллагааны бүдүүвчинд үзүүлснээр бэлтгэл ажлын хүрээнд урьдчилсан судалгаанууд, ТЭЗҮ боловсруулах, Урьдчилсан болон Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлууд багтана. Нарийвчилсан зураг төсөл, Төсвийн урьдчилсан тооцоонд үндэслэн Худалдан авах ажиллагаа, Газар чөлөөлөлтийн үйл ажиллагаа зэрэг хэрэгжүүлснээр барилга угсралтын ажлуудыг АХБ-ны гэрээг баталгаажуулснаар эхлүүлдэг. Төслийн явцад барилга угсралтын ажлын явцад зохиогчийн болон захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлж ажил дуусахад Улсын комисс ажиллан, актаар баталгаажсанаар ашиглагч байгууллагад хүлээлгэн өгнө.

Барилгын тухай хуулийн 4.1.8-д заасны дагуу "барилга байгууламжийн техникийн нөхцөл гэж барилга байгууламжийг дулаан, уур, хий, цэвэр, бохир ус, цахилгаан, харилцаа холбоо, дохиолол зэрэг эх үүсвэрт холбох эрх бүхий хуулийн этгээдээс гаргах шийдвэрийг хэлнэ" гэж заасан байдаг. Иймд, Барилгын тухай хуулийн 22.1-д заасны дагуу барилга байгууламжийн техникийн нөхцөл авах хүсэлтэд гаргахад хавсаргах баримт бичгүүд нь **газрын зөвшөөрөл**, кадастрын зураг, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, эх загвар зураг, инженерийн хангамжийн хэрэгцээг тодорхойлсон мэдээлэл зэрэг болно.

★ Тиймд, төслийн хүрээнд газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн болон нарийвчилсан зураг төслийн ажлуудыг уялдуулан хийх шаардлагатай байдаг. Иймд, Газрын зөвшөөрөлгүй тохиолдолд Техникийн нөхцөл олгогдохгүй, улмаар нарийвчилсан зураг төслийг эцэслэх боломжгүй юм.


Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрт зааснаар хөтөлбөрийн зорилго нь зорилтот дэд төвүүдийн доторх авто зам болон хотын үйлчилгээг өргөтгөх, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах, дэд төвүүд дэх эдийн засгийн болон дэд бүтцийн үйлчилгээг нэмэгдүүлэх, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, хот байгуулалтын хөтөлбөрийн менежмент, үйлчилгээг хүргэх чиглэлээр институцийг бэхжүүлж, чадавхыг бүрдүүлэх замаар 6 дэд төвийн хөгжлийн суурь нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Хөрөнгө оруулалтын хэлбэрээс хамааран хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах байдлаар ангилан үзнэ. Үүнд:

- Зорилтот дэд төвүүдэд инженерийн дэд бүтцийн асуудлыг цогцоор нь шийдэх биет хөрөнгө оруулалт болон
- Дэд төвийн хөгжлийн төлөвлөгөөг оролцооны аргаар боловсруулан хэрэгжүүлэх арга зам, механизмыг тодорхойлох биет бус хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа.




Төсөл 1-ийн хүрээнд хамрагдах Баянхошуу, Сэлбэ дэд төвүүд нь газар нутгийн хувьд нийт 318 га талбайг хамарна. Үүний 162 га газар нь Баянхошуу дэд төвд (нийт 6 хорооны газар нутаг), 156 га нь Сэлбэ дэд төвд (нийт 2 дүүргийн 4 хорооны газар нутаг) байна.

Баянхошуу дэд төв



Сэлбэ дэд төв



Хөтөлбөрийн хэрэгжилтийн жинлэсэн нийт явц 30,48% буюу төслийн үе шат тус бүрээр хэрэгжилтийн явцыг доорх хүснэгтэд харуулав.

	Хуваарилсан жин		Бодит явц	Жинлэсэн явц
Хөтөлбөр эхлүүлэх бэлтгэл	2.00%		100%	2.00%
Хөтөлбөрийн үе шат 1	32%	Газар чөлөөлөлт	98.44%	
		Худалдан авалт	99.46%	
		Барилга угсралт	55.65%	
		Зөвлөх үйлчилгээ	93.22%	
		Нийт явц	74.27%	23.76%
Хөтөлбөрийн үе шат 2	37%	Газар чөлөөлөлт	9.12%	
		Худалдан авалт	17.69%	
		Барилга угсралт	7.75%	
		Зөвлөх үйлчилгээ	1.78%	
		Нийт явц	12.76%	4.72%
Хөтөлбөрийн үе шат 3	28%	Газар чөлөөлөлт		0%
		Худалдан авалт		0%
		Барилга угсралт		0%
		Зөвлөх үйлчилгээ		0%
		Нийт явц		0%
Хөтөлбөрийн хаалт	1.00%		0%	0%
НИЙТ	100.0%		27.16%	30.48%

III. Хөтөлбөрийн I үе шат - Баянхошуу, Сэлбэ дэд төв



Тайлангийн хугацаанд төслийн нийт хэрэгжилтийн явц 74.27% хүрсэн ба энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.44%-иар өссөн бол эхний улиралтай харьцуулахад 16.91%-иар өссөн байна.

Төсөл 1-ийн хэрэгжилтийн явцыг төслийн бүрэлдэхүүн тус бүрээр дэлгэрэнгүй тайлагнасан болно.

Бүрэлдэхүүн 1. Авто зам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх

Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаа

Төслийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг үндэслэн АХБ-ны Хамгааллын бодлого, журмын дагуу зохион байгуулахаар МУ-ын Засгийн газар үүрэг хүлээсэн ба үүнд холбогдох зардлыг нийслэлийн төсвөөс бүрэн хариуцаж, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн чиг үүргийг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба газар хэрэгжүүлэхээр хүлээсэн.

Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн хамрах хүрээ, Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө нийт 8, Нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд өртсөн иргэдийн нийгэм, эдийн засгийн судалгаа нийт 60 гаруй боть, Нөлөөлөлд өртсөн иргэдийн газар, хөрөнгийн үнэлгээний 8, Нүүлгэн шилжүүлэлтийн хөндлөнгийн үнэлгээний тайлан зэрэг нийт 80 орчим баримт бичгүүдийг боловсруулахад оролцож, Азийн хөгжлийн банк, Нийслэлийн Засаг даргаар батлуулан, хэрэгжүүлж ажилласан.

Байршил	Ажлын нэр	Нөлөөлөлд өртсөн өрхийн тоо			
		Нийт	хагас	бүтэн	газрын эрхгүй
Баянхошуу дэд төв	Зам, инженерийн шугам сүлжээ	445	209	130	106
	Цэцэрлэг, МСҮТ, Цахилгааны 35/10кВ-ын дэд өртөө	27	0	27	0
	Усан сан	13	1	12	0
	Дулааны төвлөрсөн дулаанд холбох 3.2 км шугам	43	32	11	0
	Төвлөрсөн дулаанд холбох	8	4	4	0
	Үерийн далан	20	16	4	0
	Бохир усны коллекторын ажил	77	77	0	0
Сэлбэ дэд төв	Зам, инженерийн шугам сүлжээ	479	147	187	145
	Дулааны станц	27	0	26	1
	Цэцэрлэг, МСҮТ	19	0	19	0
	Бохир усны коллекторын ажил	17	17	0	0
КТМС-с Талх чихэр хүртэлх цэвэр болон бохир усны 11 км шугам		11	7	3	1
Нийт		1186	510	423	253

Хөтөлбөрийн I үе шатанд Баянхошуу, Сэлбэ дэд төвийн байршилд хэсэгчлэн 510, бүтнээр 423 нэгж талбарын газрыг чөлөөлж нийт 1186 өрх нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд өртсөн байна.

Үзүүлэлт	Бүгд	Баянхошуу дэд төв	Сэлбэ дэд төв	КТМС-с Талх чихэр хүртлэх цэвэр болон бохир усны 11 км шугам
Нийт нөлөөлөлд өртсөн өрх	1186	633	542	11
Бүтнээр	510	339	164	7
Хэсэгчилснээр	423	188	232	3
Хашаанд хамт амьдардаг өрх	253	106	146	1
Нийт зөвшилцсөн өрх	1147	605	534	8
Бүтнээр	479	319	156	4
Хэсэгчилснээр	415	180	232	3
Хашаанд хамт амьдардаг өрх	253	106	146	1
Нөхөн олговрын захирамж батлагдсан өрх	1137	601	528	8
Бүтнээр	470	316	150	4
Хэсэгчилснээр	414	179	232	3
Хашаанд хамт амьдардаг өрх	253	106	146	1
Нийт нөхөн олговроо хүлээн авсан	1095	576	514	5
Бүтнээр	463	316	146	1
Хэсэгчилснээр	414	179	232	3
Хашаанд хамт амьдардаг өрх	218	81	136	1

Нийслэлийн төсвөөс 2017-2019 онуудад нөлөөлөлд өртсөн иргэдийн нөхөн олговорт нийт 39.6 тэрбум төгрөг, дэмжлэгт 256 сая төгрөгийг зарцуулаад байна. Хэсэгчлэн өртсөн нийт 313 нэгж талбарын кадастрын зургийг шинэчлэн хийлгэж, Нийслэлийн Газар зохион байгуулалтын Газар чөлөөлөх хэлтсээр дамжуулан газрын мэдээллийн нэгдсэн санд 170 орчим нэгж талбарын өөрчлөлтийг хийлгэж, 90 орчим айлын газрын гэрчилгээг холбогдох дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээр баталгаажуулан, гаргуулж иргэдэд олгож эхэлсэн. Мөн нөлөөлөлд өртсөн айл өрхийн хашаанд хамт амьдарч байсан газрын эрхгүй 253 өрхөд газар олгох ажлыг Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан гэсэн дөрвөн дүүрэгт 37 байршилд 200-290 м² газар, Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо, Морингийн даваанд 250 м² газар, НОСК-ийн түрээслээд өмчлөх орон сууцны хөтөлбөрт хамруулах ажлыг хийж гүйцэтгэж байна.

I. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн явц



Тайлангийн хугацаанд газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн явц 98.58%-д хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.66%-иар өссөн. Газар чөлөөлөлт удааширсан шалтгаанууд:

- (i) Зөвшилцсөн иргэдийн нөхөн олговор олгох НЗД-ын захирамж гарах, нөхөн олговор шилжүүлэх явц олон үе шаттай, хугацаа алддаг;
- (ii) Иргэд газраа чөлөөлөх боломжгүйгээс зургийн өөрчлөлт хийгдэж шинээр айлуудтай нэмж зөвшилцөх шаардлага бий болсон.

Баянхошуу, Сэлбэ дэд төвийн хувьд 2019 онд авто зам, инженерийн шугам сүлжээний трассын байршилд нийт 978 өрх нөлөөлөлд өртсөн бөгөөд Нийслэлийн Засаг даргын “Хөрөнгө гаргах тухай” захирамж гаргуулан газар, үл хөдлөх хөрөнгийн нөхөн олговрыг олгож, трассын газрыг чөлөөлөх ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс 967 өрхтэй зөвшилцөж, 915 өрхийн нөхөн олговрыг бүрэн олгуулж, трассын талбайг чөлөөлж, барилга угсралтын ажилд бэлтгэж ажиллав.



№	Байршил	Ажлын нэр	Нөлөөлөлд өртсөн нийт өрхийн тоо	2019 онд				
				Зөвшилцсон нийт өрхийн тоо	НЗД-ын захирамжаар нөхөн олговроо хүлээн авсан өрхийн тоо /өссөн дүнгээр/			
					I улирал	II улирал	III улирал	IV улирал
1	Баянхошуу дэд төв	Зам, инженерийн шугам сүлжээ	445	445	279	303	365	416
		Дулааны төвлөрсөн дулаанд холбох 3.2 км шугам	43	43	5	24	42	43
2	Сэлбэ дэд төв	Зам, инженерийн шугам сүлжээ	479	471	280	338	354	451
3	КТМС-с Талх чихэр хүртэлх цэвэр болон бохир усны 11 км шугам		11	8	0	2	4	5
Нийт			978	967	564	667	765	915

II. Кадастрын зураг, газрын гэрчилгээний өөрчлөлт

Дэд төвүүдийн бүтээн байгуулалтын ажлын трасст хагас өртөж газраа чөлөөлсөн нийт 313 нэгж талбарын кадастрын зургийн өөрчлөлтийг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлснийг 08 дугаар сараас эхлэн хийж байгаа бөгөөд 170 орчим нэгж талбарын өөрчлөлт хийгдсэн.

Нөлөөлөлд хагас өртсөн айлуудын кадастрын зураглал, гэрчилгээг шинэчлэн гаргуулахаар дүүргийн Газар зохион байгуулалтын албанд нийт 146 гаруй өрхийн бүртгэлийн материалыг бэлтгэн хүргүүлснээс 95 өрхийн кадастрын зураг, газар өмчлөлийн гэрчилгээг шинэчлэн гаргаж, иргэдэд буцаан олгоод байна.

III. Нөлөөлөлд өртсөн газар эзэмших, өмчлөх эрхгүй иргэдэд газар олгох

АХБ-ны Нийгмийн хамгааллын бодлогын дагуу боловсруулан баталсан “Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө”-нд заасны дагуу төслийн нөлөөлөлд өртөж, нүүх шаардлагатай болсон өөрийн гэсэн газрын эрхгүй өрх тус бүрд одоогийн амьдарч буй газраас нь дордуулахгүй нөхцөлтэй газар олгох шаардлагатай гэж заасан байдаг. Энэ заалтыг биелүүлээгүйн улмаас АХБ-наас төслийг 2 сар орчим хугацаанд зогсоосон.

Төслийн хүрээнд нөлөөлөлд өртсөн нийт 978 нэгж талбарын 412 нь газраа бүтэн чөлөөлж байгаа бөгөөд 48% нь хашаандаа хоёроос дээш өрхтэй амьдарч байсан. Иймээс урьдчилсан байдлаар газрын эрхгүй амьдарч байгаад нүүсэн болон нүүх шаардлагатай болсон 253 өрх байна.

Дээрх 253 газрын эрхгүй өрхүүдэд суурь дэд бүтцээр хангагдсан нийтийн үйлчилгээтэй газар олгох эсвэл зорилтот бүлгийн орон сууц санал болгох зэрэг боломжит хувилбаруудыг баталгаажуулж, тухайн иргэдтэй зөвшилцөн сонгосон хувилбаруудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар нийслэлийн Засаг даргын орлогч Ж.Батбаясгалан НЗДТГ, НГЗБА, НОСК ХК, Төсөл хэрэгжүүлэх нэгж, нийслэлийн Засаг даргын 2018 оны захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хамтран ажиллах ажлын удирдамжийг баталсан. НӨАУГ-аас ирүүлсэн БЗД, СБД, ЧД, СХД-ийн 37 байршил, Хан-Уул дүүргийн Морингийн даваа зэрэг байршлуудад орчны судалгаа хийн иргэдэд олгуулахаар ажиллаж байна. НЗДТГ-т эдгээр газруудыг эзэмшүүлэхээр НИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэх хүсэлтийг эдгээр Нийслэлийн харьяа байгууллагууд гарган төслийн захирал Ж.Батбаясгаланд хүргүүлэн шийдвэр хүлээж байна. 2019 оны 12 дугаар сарын байдлаар нийт 51 иргэн 37 байршилд, 10 иргэн Морингийн даваанд, түрээслээд өмчлөх байранд 8 иргэн авахаар бүртгүүлээд байна.

IV. Нөлөөлөлд өртсөн иргэдэд нөхөн олговрын зөрүү олгох

2018 оны 4 дүгээр сард нөлөөлөлд өртөгч иргэдийн АХБ-ны Хариуцлагын газар гаргасан гомдлын дагуу НЗДТГ, АХБ-ны төлөөлөл, Төсөл хэрэгжүүлэх нэгж, иргэд, төрийн бус байгууллагууд зэрэг талууд оролцсон “Санамж бичиг”-ийг олон удаагийн уулзалт, хэлэлцээрийн үр дүнд 07 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан. Уг баримт бичгийн дагуу иргэдийн газрын үнэлгээг Сэлбэ дэд төвд 1 м2 нь



80.000 төгрөг, Баянхошуу дэд төвд 1 м2 нь 60.000 төгрөгөөр тооцож авах, шилжилтийн үеийн дэмжлэг 1.800.000 төгрөг, нүүх зардал 250.000 төгрөгийг нүүж байгаа айл бүрт нөхөн олговор болгон олгохоор тогтсон.

Үүний дагуу Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн нөлөөлөлд өртсөн нийт 473 нэгж талбар дээр газрын үнэлгээ нэмэгдсэнтэй холбоотой нэмэлт төлбөр, нүүлгэлтийн зардал, амьжиргааг дэмжих шилжилтийн үеийн дэмжлэг зэрэг нөхөн олговрын захирамж гарснаас 438 айлтай нөхөн олговрын гэрээ байгуулж, зөрүү нөхөн олговрыг олгосон.

V. Хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлс

2019 оны 12-р сарын 30-ны байдлаар төслийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж буй дараах асуудлууд байна. Үүнд:

- Кадастрын зургийн өөрчлөлт:** Төслийн хүрээнд Баянхошуу, Сэлбэ дэд төвд баригдах авто зам, инженерийн шугам сүлжээний зурваст өртсөн 313 нэгж талбарын кадастрын зургийн өөрчлөлтийг мэдээллийн санд бүртгүүлэх албан бичгийг 2018 оны 11 дүгээр сараас хойш удаа дараа явуулсан. Одоогийн байдлаар 120 гаруй иргэний мэдээллийг шинэчилсэн бөгөөд мэдээлэл шинэчлэх ажлыг 1 хүн хариуцан гүйцэтгэж байгаа нь хүндрэл учруулж байна.
- Нөлөөлөлд өртсөн газар эзэмших, өмчлөх эрхгүй иргэдэд газар олгох:** АХБ-ны Нийгмийн хамгааллын бодлогын дагуу боловсруулан баталсан “Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө”-нд заасны дагуу төслийн нөлөөлөлд өртөж, нүүх шаардлагатай болсон өөрийн гэсэн газрын эрхгүй өрх тус бүрд одоогийн амьдарч буй газраас нь дордуулахгүй нөхцөлтэй газар олгох шаардлагатай гэж заасан. Үүний дагуу нөлөөлөлд өртсөн газрын эрхгүй амьдарч байгаад нүүсэн болон нүүх шаардлагатай болсон 253 өрхийн газрын асуудлыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байна.
- Нөхөн олговрын захирамж, төлбөрийн шилжүүлэг:** Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн иргэд газраа өгөхөөр зөвшилцөж гэрээ байгуулснаас хойш нөхөн олговрын санхүүжилт нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 10 үе шат, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 6 үе шат дамжин иргэнд олгогддог. Уг явцыг дараах схемд үзүүлэв.



Одоогийн хэрэгжүүлж буй үе шатаар газар чөлөөлөхөд ажлын 80 орчим хоног зарцуулж байгаа нь төслийн хэрэгжилтийг удаашруулж байна. Зөвшилцөн гэрээ байгуулсан иргэдэд нөхөн олговор олгох Нийслэлийн Засаг даргын захирамж гарч, нөхөн олговор олгох асуудал удаашралтай байгаа нь иргэдийг бухимдуулж, улмаар газраа чөлөөлөхөөс татгалзах эрсдэлийг бий болгож байна. Энэ нь 2019 оны туршид барилга угсралтын ажлыг төлөвлөгөөний дагуу хэвийн явуулахад хүндрэл учруулж байсан ба энэ талаар сар бүр төслийн үйл ажиллагааны тайланд тайлагнах, явцыг түргэвчлэн оновчтой хувилбар бий болгох санал гарган удирдлагын хуралд танилцуулах зэргээр ажилласан боловч үр дүнд хүрээгүй.

Худалдан авах ажиллагааны явц



Хөтөлбөрийн I үе шатны хүрээнд АХБ болон ЕХОБ-ны санхүүжилтийн 4 төрлийн эх үүсвэрээс нийт 42 худалдан авалтын багц байгаагаас 2019 оны 12 дүгээр сарын 31-ний байдлаар 39 багц худалдан авах ажиллагааг гүйцэтгэж, гэрээ байгуулсан.

Тайлангийн хугацаанд төслийн худалдан авах ажиллагааны явц 99.46%-тай хэрэгжиж байна.

Төлөвлөгөөний дагуу дараах худалдан авах ажиллагааг гүйцэтгэж байна. Үүнд:

- Хөтөлбөрийн I үе шатны нийт худалдан авалт**
- 
- | Хөтөлбөрийн I үе шатны нийт худалдан авалт |
|--|
| <ul style="list-style-type: none"> ■ Барилга угсралтын ажил ■ Зөвлөх үйлчилгээ ■ Барааны худалдан авалт |



Мөн тайлангийн хугацаанд CSOI дугаартай “Хотын үндсэн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаа, менежментийг сайжруулах болон байгууллагын болон эрх зүйн шинэчлэлийг дэмжих” зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг гүйцэтгэн 2019 оны 12-р сарын 20-ны өдөр гэрээ байгуулав. Уг зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг НХААГ зохион байгуулж гүйцэтгэсэн бөгөөд үүнд нийт 1123 хоног зарцуулсан байна.

2019 онд худалдан авах ажиллагааны хүрээнд барилга угсралтын ажил - 5, зөвлөх үйлчилгээ - 4, бараа худалдан авалт - 3, түлхүүр гардуулах нөхцөлтэй - 1 буюу нийт 9 багцын 13 бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулан ажиллаж байна.

Дараах хүснэгтэд 2019 онд гэрээ байгуулсан барилга угсралтын ажлуудын мэдээллийг харуулав.

2019 оны 12-р сарын 31-ний байдлаар

Д/д	ХАА-ны багцын дугаар, нэр	Гэрээ байгуулсан огноо	Шалгарсан гүйцэтгэгч
Барилга угсралтын ажил			
1	SSF05 Багц 1: Сэлбэ дэд төвд барих 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажил	2019.01.17	Цаст Констракшн ХХК



2	SSF05 Багц 2: Сэлбэ дэд төвд барих МСҮТ, бизнес инкубатор төвийн барилга угсралтын ажил	2019.01.17	Бридж Констракшн ХХК, Монхас ХХК нарын түншлэл
3	BSLS09 Багц 2: Сэлбэ дэд төвийн үерийн далан дагуух тохижилтын ажил	2019.02.28	Бодь Пропертийз ХХК
4	WSC16A: Баянхошуу дэд төвийн цэвэр бохир ус, халуун ус болон дулааны шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, угсралт суурилуулалт болон нийлүүлэлтийн ажил /Түлхүүр гардуулах нөхцөлтэй/	2019.07.24	Одкон Холдинг ХХК, Улаанбаатар Барилга ХХК нарын түншлэл
5	BSLS09 Багц 1 (дахин зар): Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын суваг дагуух талбайн тохижилтын ажил	2019.08.02	Дүүрэн Трейд ХХК, Байгууламж ХХК нарын түншлэл
6	BSDF07B (дахин зар): Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажил	2019.08.20	Монгол Менежмент Төв ХХК, Улаанбаатар Менежмент ХХК нарын түншлэл
Зөвлөх үйлчилгээ			
1	CSDD-BSDF07B: Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн ажлын зураг шинэчлэх, зураг төсөл боловсруулах, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээ	2019.01.21	Усны эрчим ХХК
2	CSDD-GWD: Сэлбэ дэд төвд төлөвлөсөн авто замын борооны ус зайлуулах шугамыг хөрсний усны түвшинг доошлуулах шугам болгох өөрчлөлтийн зураг төсөл боловсруулах, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээ	2019.01.21	Гидродизайн инноваци ХХК
3	PP01-DD: Орлогд нийцсэн орон сууцны загвар төслийн зураг боловсруулах хяналтыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээ	2019.01.29	Аркетайп Монголиа ХХК
4	CSDA: Зохиогчийн хяналт гүйцэтгэх зөвлөх үйлчилгээ	2019.06.25	Ричвелл Инженеринг ХХК
Бараа худалдан авалт			
1	BEF Багц-1: Баянхошуу дэд төв дэх бизнес инкубатор, мэргэжлийн сургалтын төвд "Багц-1"-ийн хүрээнд мэдээлэл технологийн тоног төхөөрөмж нийлүүлэх	2019.03.26	"Ай Ти Зон" ХХК
2	BEF Багц-2: Баянхошуу дэд төв дэх бизнес инкубатор, мэргэжлийн сургалтын төвд "Багц-2"-ын хүрээнд үсчин болон оёдолчны тоног төхөөрөмж нийлүүлэх	2019.03.26	"Декора" ХХК
3	BEF Багц-3: Баянхошуу дэд төв дэх бизнес инкубатор, мэргэжлийн сургалтын төвд "Багц-3"-ын хүрээнд сургалтын төвийн тавилга нийлүүлэх	2019.03.26	"Профешнал Сивил Инженеринг Констракшн" ХХК

Барилга угсралтын ажлын явц



Тайлангийн хугацаанд Барилга угсралтын ажлын нийт явц 70% буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27%-иар өссөн байна.

Баянхошуу дэд төвд хийж буй барилга угсралтын ажлууд

1. Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах дулааны 11и магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил

Хүчин чадал:	2ф500мм шугамыг 2ф700мм болгон өргөтгөх 1600 м; 2ф400мм шугамыг 2ф600мм болгон өргөтгөх 1600 м;
Гүйцэтгэгч:	“ЧММ” ХХК, “Эс Энд Эй Трейд” ХХК-иудын түншлэл
Гэрээний дугаар:	ВНФ06 - Ажлын явц: 100%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	Дулааны 11и магистраль шугамыг өргөтгөх ажлын хүрээнд 2ф500мм шугамыг 2ф700мм диаметртай болгон өргөтгөх 1,6 км шугам, 2ф400мм шугамыг 2ф600мм диаметртай болгон өргөтгөх 1,6 км шугамын барилга угсралтын ажлуудыг тохижилт, нөхөн сэргээлтийн ажлуудын хамт бүрэн хийж дуусгасан.



2. Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажил

Хүчин чадал:	2.4 км урттай үерийн хамгаалалтын суваг;
Гүйцэтгэгч:	“Хангилцаг” ХХК
Гэрээний дугаар:	BSDF07, Багц 1 - Ажлын явц: 100%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	Сонгинохайрхан дүүргийн 9, 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 2.4 км урттай үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлыг бүрэн хийж дуусгасан.



3. Баянхошуу дэд төвд усан сан, насос станцын барилга угсралт болон ус хангамжийн шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажил

Хүчин чадал:	1000м3 хүчин чадалтай усан сан; Доод насос станцын барилга-1, Өргөлтийн насос станцын барилга-1; Ус дамжуулах шугам - 5814м;
Гүйцэтгэгч:	“Бумбод” ХХК, “Одкон” ХХК-иудын түншлэл
Гэрээний дугаар:	BSWR10, Багц 1 - Ажлын явц: 91%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	1000м3 хүчин чадалтай усан сангийн барилга угсралтын ажил 90%-тай байна. Усан сангийн туршилт тохируулга хийгдэж байна. - Насос станц болон өргөлтийн насос станцын барилга угсралтын ажил 90%-тай байна. Насос суурилуулалтын ажил хийгдэж байна. - Ус дамжуулах 5814м шугамын ажил 90%-тай хийгдэж байна.



4. Баянхошуу дэд төвд баригдах цахилгаан, холбооны шугам сүлжээ, барилга угсралтын ажил

Хүчин чадал:	2*16/35/10МВА-ын цахилгааны дэд станц - 1ш; 10кВ-ийн хуваарилах байгууламж - 1ш; 2*630/10/0.4кВА-ын хаалттай дэд өртөө - 2ш; Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төв - 1ш; 35кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам - 4000м; 10 кВ кабелийн шугам - 2300м; Холбооны худаг, сувагчлал, шилэн кабель - 2948м;
Гүйцэтгэгч:	“Одкон Холдинг” ХХК, “Одкон Эрчим” ХХК-ийн түншлэл
Гэрээний дугаар:	ВЕС13 - Ажлын явц: 71%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	• Барилга угсралтын ажил: • 35/10кВ-ийн дэд станцын барилга угсралтын ажил 55%-тай (дотор заслын ажил хийгдэж байна) • 2ш хаалттай дэд өртөөний барилгын ажил дууссан ба тоноглол суурилуулах ажил хүлээгдэж байна. • 10кВ-ийн хуваарилах байгууламжийн барилга угсралтын ажил 90%-тай (дотор заслын ажил хийгдэж байна.) • Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төвийн барилга угсралтын ажил 40%-тай хийж гүйцэтгэсэн. • Нийт 4000м-ийн урттай 35кВ-ийн кабелийн шугамын ажил бүрэн хийгдэж дууссан. • Нийт 2300м-ийн урттай 10кВ-ийн кабелийн шугамын ажил бүрэн хийгдэж дууссан. • Нийт 2948м-ийн урттай холбооны худаг, сувагчлал, шилэн кабелийн ажил бүрэн хийгдэж дууссан.



5. Баянхошуу дэд төвд авто зам, дулааны шугам сүлжээ болон бусад дэд бүтцийн шугам сүлжээний ажил (үе шат-1)

Хүчин чадал:	Цэвэр усны шугам - 2976 м; Бохир усны шугам - 3915 м; Авто зам - 2885м; Дулааны шугам - 7432 м; Ус дулаан дамжуулах төв - бш; Авто замын трасст давхцаж буй цахилгааны шон зөөж шилжүүлэх - 3210м; Авто замын трасст давхцаж буй холбооны шугам зөөж шилжүүлэх - 29ш;
Гүйцэтгэгч:	БНХАУ-ын “Янчэнг Шингтуо Констракшн Инженеринг” ХХК
Гэрээний дугаар:	BRDH11 - Ажлын явц: 41%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	• Ариутгах татуургын 3205м шугамын угсралтын ажил хийгдсэн. • Цэвэр усны 1581м шугамын угсралтын ажил хийгдсэн. • Нийт дулааны 7432м шугамын 1800м-ийг угсарч суурилуулсан. • Авто замын борооны ус зайлуулах шугамын ажил 13.4%-тай хийгдсэн. • Холбооны нийт 29 шугам зөөж шилжүүлэх ажил бүрэн дууссан. • Цахилгааны шон зөөж шилжүүлэх ажил 78%-тай хийгдсэн. • УДДТ-1-н барилга угсралтын ажлын нийт гүйцэтгэл 70%-тай (гадна өрлөг 100%, дээвэр 80%, хаалга, цонх суулгах, дотор шавардлага, хамар хана өрөх, шал цутгах болон дотор заслын ажлууд хүлээгдэж байна) • УДДТ-5-н барилга угсралтын ажлын нийт гүйцэтгэл 30%-тай (цутгамал төмөр бетон араг бүтээц угсрах, гадна өрлөг, дээвэр, хаалга, цонх суулгах, дотор шавардлага, хамар хана өрөх, шал цутгах болон дотор засал зэрэг ажлууд хүлээгдэж байна.) • УДДТ-6-н барилга угсралтын ажлын нийт гүйцэтгэл 50%-тай (гадна өрлөг 60%, дээвэр 80%, хаалга, цонх суулгах, дотор шавардлага, хамар хана өрөх, шал цутгах болон дотор заслын ажлууд хүлээгдэж байна) • УДДТ-7-н барилга угсралтын ажлын нийт гүйцэтгэл 65%-тай (гадна өрлөг 60%, дээвэр 80%, хаалга, цонх суулгах, дотор шавардлага, хамар хана өрөх, шал цутгах болон дотор заслын ажлууд хүлээгдэж байна) хийгдэж байна.



УДДТ-ийн барилга



6. Баянхошуу дэд төвд авто зам, дулааны шугам сүлжээ болон бусад дэд бүтцийн шугам сүлжээний ажил (үе шат-2)

Хүчин чадал:	Цэвэр усны шугам - 2170м; Бохир усны шугам - 4566.8м; Авто зам - 3653м; Дулааны шугам - 3450м; Ус түгээх байр - 1ш; Ус дулаан дамжуулах төв - 6ш;
Гүйцэтгэгч:	ХБНГУ-ын “Людвиг Пфайфер Кассел”, “Людвиг Пфайфер Лайпциг” ХХК-иудын түншлэл
Гэрээний дугаар:	BRDH14 - Ажлын явц: 38%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	• Ариутгах татуургын нийт 4566.8м шугамын ажлын 2800м-ийг угсарч суурилуулсан. • Цэвэр усны 2170м шугамын ажлын 1975.8м-ийг угсарч суурилуулсан. • Авто замын борооны ус зайлуулах шугамын ажил 31.3%-тай хийгдсэн. • Дулааны нийт 3450м шугамын ажлын 376м-ийг угсарч суурилуулсан. • УДДТ-9-н барилга угсралтын ажлын нийт гүйцэтгэл 30%-тай хийгдсэн. • УДДТ-10-н барилга угсралтын ажлын нийт гүйцэтгэл 30%-тай тус тус хийгдэж байна. • Ус түгээх байрны барилга угсралтын ажил 95%-тай (дотор заслын ажил хийгдэж байна.)



7. Баянхошуу дэд төвийн усан хангамж, ариутгах татуурга, халуун ус болон дулааны шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, бараа тоног төхөөрөмж нийлүүлэх болон суурилуулах ажил

Хүчин чадал:	1. Хилчин хотхоныг төвлөрсөн дулаанд холбох - 1.0 км; 2. 227-р цэцэрлэг, СХД-ийн 7-р хорооны барилгыг төвлөрсөн дулаанд холбох - 0.32 км; 3. СХД-ийн Эрүүл мэндийн 3-р амбулатори, Дүүргийн цагдаагийн 2-р хэлтэс, 163, 78-р цэцэрлэгүүд, 76-р сургууль, сургуулийн өргөтгөл, 9-р хорооны барилгыг төвлөрсөн дулаанд холбох нийт 0.8 км, болон бохир усны шугамд холбох - 1.0 км; 4. 67-р сургууль, 117-р цэцэрлэгийг төвлөрсөн дулааны шугамд холбох - 0.6 км, болон бохир усны шугамд холбох - 0.4 км; 5. Баянхошуу дэд төвийн Түр суурьшуулах орон сууцны барилгыг төвлөрсөн дулаанд холбох - 0.4 км, болон бохир усны шугамд холбох - 0.4 км;
Гүйцэтгэгч:	“Одкон Холдинг” ХХК, “Улаанбаатар Барилга” ХХК-ийн түншлэл
Гэрээний дугаар:	WSC16A - Ажлын явц: 38.5%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	• 5 байршлын улсын болон орон нутгийн чанартай нийгмийн барилга байгууламжуудыг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбох ажил хийхээс Хилчин хотхоныг төвлөрсөн дулаанд холбох дулааны шугамын барилга угсралтын ажил бүрэн хийгдэж дууссан. • Бусад 4 байршлын ажлын зураг төсөл боловсруулагдаж, УБДС ТӨХК-аар хянуулж байна.



8. Баянхошуу дэд төвийн тохижилтын ажил

Хүчин чадал:	Үерийн далангийн дагуу хийгдэх гадна тохижилт, ногоон байгууламж- 4.65 га;
Гүйцэтгэгч:	“Дүүрэн Трейд” ХХК, “Байгууламж” ХХК-ийн түншлэл
Гэрээний дугаар:	BSLS09, Багц 1 - Ажлын явц: 36%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	- Гадна замын тохижилтын ажил нийт 2691м2 хийгдсэн. - Үерийн далангийн явган хүний гүүр нийт 9ш барьсан. - Түүх соёлын дурсгалт суварга 1ш, бурхан 1ш бүтээх ажил хийгдсэн.



9. Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажил

Хүчин чадал:	Сувгийн угсралтын ажил - 2300м; Эргийн бэхлэгээний ажил - 10592м; Ус цуглуулах худаг - 2ш; Ариутгах татуургын шугамын бэхлэгээний ажил; Цахилгааны шугам зөөж, шилжүүлэх;
Гүйцэтгэгч:	“Монгол Менежмент төв” ХХК, “Улаанбаатар Менежмент” ХХК-ийн түншлэл
Гэрээний дугаар:	BSDF07B - Ажлын явц: 28%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	- Нийт 2300м үерийн хамгаалалтын сувгийн 486м-ийн барилга угсралтын ажил хийгдсэн. - Ус цуглуулах худаг №1 барилга угсралтын ажил 75%-тай хийгдсэн. - Ус цуглуулах худаг №2 барилга угсралтын ажил бүрэн дууссан. - Эргийн бэхлэгээний угсралтын ажил нийт 4503м хийгдсэн. - Цахилгааны шугам зөөж, шилжүүлэх ажлын 5 тулгуурыг зөөн шилжүүлсэн.



10. Баянхошуу дэд төвд орлогод нийцсэн орон сууц ба хот шинэчлэлтийн төслийн туршилтын загвар барилга барих ажил, 20 айлын орон сууц

Хүчин чадал:	3-4 давхар, 4 блок бүхий 20 айлын орон сууц
Гүйцэтгэгч:	-
Гэрээний дугаар:	PP01-SW - Ажлын явц: 10%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	• 2019.06 сард нөлөөлөлд өртсөн айлуудтай зөвшилцөж, газрыг бүрэн чөлөөлсөн. • Архитектур төлөвлөлтийн даалгаврыг НХБХГ-аас авсан. • Нарийвчилсан зураг төсөл экспертизээр батлагдсан. • Тендерийг 2019.12.06-ны өдөр нээж, үнэлгээ хийж байна.



Сэлбэ дэд төвд хийж буй барилга угсралтын ажлууд:

1. Сэлбэ дэд төвд усан сан, насос станцын барилга угсралт болон ус хангамжийн шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажил

Хүчин чадал:	1000м ³ хүчин чадалтай усан сан; Доод насос станцын барилга-1, Өргөлтийн насос станцын барилга-1; Ус дамжуулах шугам - 5370м;
Гүйцэтгэгч:	“Санжат” ХХК
Гэрээний дугаар:	BSWR10, Багц 2 - Ажлын явц: 100%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	- Барилга угсралтын ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжиж бүрэн дууссан. 2019.08.31-ний байдлаар нийт барилга угсралтын ажил 100% бүрэн дуусч, байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж, 2019.10.21-ний өдрийн 2019/483 дугаар болон 2019.11.29-ний өдрийн 2019/701 дугаар комиссын актуудаар баталгаажсан. - Туршилт, тохируулга, угаалга шахалт, тест хийх ажил бэлэн болсон.



2. Сэлбэ дэд төвд үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралт болон ҮХС-ийн хамгаалалтын хайсны угсралт суурилуулалтын ажил

Хүчин чадал:	Үерийн хамгаалал, далан суваг – 2423м
Гүйцэтгэгч:	“Экспресс Зам” ХХК
Гэрээний дугаар:	BSDF07, Багц 2 - Ажлын явц: 79%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	• Үерийн хамгаалалтын нийт 7 сувгийн барилга угсралтын ажлаас 5 суваг буюу 1.26 км-ийн ҮХС-ын ажил хийгдэж, байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж, 2018.12.05-ны өдрийн 2018/690 дугаар комиссын актаар баталгаажсан. • Үлдсэн 2 ҮХС-ын барилга угсралтын ажил Вайт Финикс ХХК-ийн гүйцэтгэж байгаа инженерийн шугам сүлжээ болон дэд бүтцийн ажлуудаас хамааран хүлээгдэж байна. Барилга угсралтын ажлын технологийн дарааллаар хөрсний усны шугамын барилга угсралтын ажил хийсний дараа авто замын далан болон үерийн хамгаалалтын сувгийн ажлууд хийгдэнэ.



3. Сэлбэ дэд төвд баригдах 24м, 30м, 60м-ийн урттай 3 ширхэг төмөр бетон гүүрийн барилгын ажил

Хүчин чадал:	24м, 30м, 60м урттай 3 гүүр;
Гүйцэтгэгч:	“ЗМЗ” ХХК
Гэрээний дугаар:	SBR08 - Ажлын явц: 78%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	Барилга угсралтын ажил төлөвлөгөөний дагуу хийгдсэн. • 60м-ийн урттай гүүр - 90%, • 30м-ийн урттай гүүр - 59%, • 24м-ийн урттай гүүр - 81%-ийг тус тус хийж гүйцэтгэсэн.



4. Сэлбэ дэд төвд баригдах цахилгаан, холбооны шугам сүлжээ, барилга угсралтын ажил

Хүчин чадал:	35кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам - 1935м; 2*16/35/10МВА-ын цахилгааны дэд станц - 1ш; 10 кВ кабелийн шугам - 549м; 2*630/10/0.4кВА хаалттай дэд өртөө - 2ш; Холбооны худаг, сувагчлал, шилэн кабель - 2768м; Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төв - 1ш;
Гүйцэтгэгч:	“Дорнын Их Гэгээ” ХХК, “Монхас” ХХК-ийн түншлэл
Гэрээний дугаар:	SEC13 - Ажлын явц: 58%

Хийж гүйцэтгэсэн ажлууд:	- 35кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугамаас 1700м шугамын угсралтын ажил хийгдсэн. - 35/10кВ-ийн дэд станцын барилга угсралтын ажил 38%-тай (10кВ-ийн хуваарилах байгууламжийн гадна ханын өрлөгийн ажил дууссан, 35кВ-ийн байрны өрлөгийн ажил эхэлсэн.) - 2ш хаалттай дэд өртөөний барилга угсралтын ажил 55%-тай (Цэцэрлэгийн хаалттай дэд өртөөний барилгын дотор заслын ажил, 2-р хаалттай дэд өртөөний барилгын өрлөгийн ажил хийгдэж байна.) - Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төвийн барилга угсралтын ажил 50%-тай (карказ цутгаж дууссан.) - 10 кВ кабелийн шугамаас 222м шугамын угсралтын ажил хийгдсэн. - Холбооны худаг, сувагчлал, шилэн кабелийн 2500м-ийг угсарч суурилуулаад байна. - 35кВ-ийн кабель шугамын ажил "Вайт Финикс" ХХК-ийн барьж байгаа авто замтай огтлолцох хэсэгт зураг төсөл зохиогчоос шийдэл гаргуулахаар хүлээгдэж байна. - Цэцэрлэгийн хаалттай дэд өртөөний 10кВ-ийн кабель шугамын ажил хийгдэж дууссан, 2-р хаалттай дэд өртөөний 10кВ-ийн кабелийн ажил эхлэх болоогүй. - Холбооны худаг сувагчлал суурилуулах ажлын "Танил Санаа" ХХК-ийн ажлын зураг боловсруулсан авто замын дагуух сувагчлалын ажил "Вайт Финикс" ХХК-ийн бохир, дулааны шугамын ажилтай уялдан хүлээгдэж байна.
--	---



5. Сэлбэ дэд төвд 28 Мвт дулааны станцын барилгын зураг төсөл, ханган нийлүүлэлт, барилга угсралтын ажил

Хүчин чадал:	28МВт хүчин чадалтай дулааны станц - 3ш зуух; Оффисын барилга – 2 давхар; Ус бэлтгэлийн барилга; Нүүрсний агуулахын барилга;
Гүйцэтгэгч:	"Хүрд" ХК, "Шиншиан Гонгшен бойлер" ХХК-ийн түншлэл
Гэрээний дугаар:	SHF06 - Ажлын явц: 56.5%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	• Дулааны станцын барилгын болон 3 зуухны суурийн ажил, суурийн нягтруулгын ажил, нүүрсний агуулахын барилгын суурь, нүүрс бутлуурын барилгын суурь, нүүрсний галлерейн бетон суурийн ажил бүрэн дууссан. • Оффисын барилга, зуухны барилга, ус бэлтгэлийн барилгын ган карказ угсралтын ажил дууссан. • Зуухны экран хоолой, экономайзер угсралтын ажлууд үргэлжилж байна. Барабаны ширмэн суурийг угсарсан. • Зуух №1,2,3-н шугам хоолойн угсралт, түлш бэлтгэлийн барилгын угсралт, оффисын барилгын гадна хана угсралт болон ус бэлтгэлийн тоноглолын бетон суурийн цутгалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.



6. Сэлбэ дэд төвд авто зам, дулааны шугам сүлжээ болон бусад дэд бүтцийн шугам сүлжээний ажил (үе шат-1)

Хүчин чадал:	Цэвэр усны шугам - 2100м; Бохир усны шугам - 5003.1м; Авто зам - 4710м; Дулааны шугам - 4042.82м; Ус дулаан дамжуулах төв - 8ш;
Гүйцэтгэгч:	“Вайт Финикс” ХХК, “Хасу Мегаватт” ХХК, “Эвт Трак” ХХК-иудын түншлэл
Гэрээний дугаар:	SRDH11 - Ажлын явц: 61%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	• 2018 онд барилга угсралтын ажил гүйцэтгэх явцад хөрсний усны түвшин тооцоолсноос өндөр гарсан. Иймд тайлангийн хугацаанд хөрсний ус зайлуулах шугамын ажлыг эхлүүлсэн. • Цэвэр усны 1560м шугамын угсралтын ажил хийгдсэн. • Ариутгах татуургын 3750м шугамын угсралтын ажил хийгдсэн. • Дулааны 3100м шугамын угсралтын ажил хийгдсэн.

	- Авто зам шугам сүлжээний трасст өртсөн цахилгаан холбооны шугамыг зөөж шилжүүлэх ажил хийгдсэн. - Авто замын барилга угсралтын ажил 25%-тай хийгдсэн. - Нийт 8 УДДТ барихаас 6 барилгын угсралтыг хийж, дотор заслын ажил хийгдэж байна. Сүүлд газар чөлөөлөлт хийгдсэн УДДТ №4 барилгын 1-р давхрын хана өрлөгийн ажил дууссан.
--	--



7. Сэлбэ дэд төвд авто зам, дулааны шугам сүлжээ болон бусад дэд бүтцийн шугам сүлжээний ажил (хэсэг-2)

Хүчин чадал:	Цэвэр усны шугам - 1870м; Бохир усны шугам - 4270.5м; Авто зам - 1888м; Дулааны шугам - 4654.4м; Ус дулаан дамжуулах төв - 6ш;
Гүйцэтгэгч:	“Набсан” ХХК, “Тэргүүн Инвест” ХХК, “Тэгш Плант” ХХК-иудын түншлэл
Гэрээний дугаар:	SRDH14 - Ажлын явц: 41%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	2018 онд барилга угсралтын ажил гүйцэтгэх явцад хөрсний усны түвшин тооцоолсноос өндөр гарсан. Иймд тайлангийн хугацаанд хөрсний ус зайлуулах шугамын ажлыг эхлүүлсэн. - Цэвэр усны 165.4м шугамын угсралтын ажил хийгдсэн. - Ариутгах татуургын 3800м шугамын угсралтын ажил хийгдсэн. - Дулааны 820м шугамын угсралтын ажил хийгдсэн. - Авто зам шугам сүлжээний трасст өртсөн цахилгаан холбооны шугамыг зөөж шилжүүлэх ажил хийгдсэн. - Авто замын барилга угсралтын ажил 34%-тай хийгдсэн. - Дамбадаржаа дэд төвд барих дулааны станцын байршил өөрчлөгдсөн тул ДХ-1-ээс ДХ-30 хүртэлх 560 метр дулааны шугамын ажлыг хойшлуулсан.



8. Сэлбэ дэд төвд үерийн далангийн дагуу хийгдэх гадна тохижилт, ногоон байгууламжийн ажил

Хүчин чадал:	Үерийн далангийн дагуу хийгдэх гадна тохижилт, ногоон байгууламж - 3.01га;
Гүйцэтгэгч:	“Бодь Пропертиз” ХХК
Гэрээний дугаар:	BSLS09, Багц 2 - Ажлын явц: 40%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	- Гадна талбай, тохижилтын ажил 57%-ийн гүйцэтгэлтэй хийгдсэн. - Түшиц хана, зүлэгний хашлагын ажил 20%-ийн гүйцэтгэлтэй хийгдсэн. - Үерийн хамгаалалтын суваг дагуух метал хайс хийх ажил 70% гүйцэтгэлтэй хийгдсэн.



Дэд төвүүдийн нутаг дэвсгэрээс гадна хийгдэж буй барилга угсралтын ажлууд

Гэр хорооллын зорилтот дэд төвүүдэд инженерийн дэд бүтцийн шугам сүлжээг өргөтгөн хийхтэй холбоотойгоор шугам сүлжээний эх үүсвэр, гол магистраль шугамуудыг өргөтгөх зайлшгүй шаардлага үүссэн.

Төв цэвэрлэх байгууламж

Төслийн хүрээнд дэд төвүүдийн бохир усны шугам сүлжээ төвлөрсөн системд холбогдож, төв цэвэрлэх байгууламж руу холбогдохоор төлөвлөгдсөн. Түүнчлэн, төв цэвэрлэх байгууламжийн бетон хийцийг сайжруулах, технологи шинэчлэлтийн ажлуудыг хийснээр дэд төвүүдээс холбогдох бохирыг хүлээж авах нөхцөл бүрдэх ба технологийн шинэчлэл нь цэвэрлэгээний чанарыг сайжруулах ач холбогдолтой.

Дэд төвүүдийг холбох шугамууд

1. Сэлбэ, Дамбадаржаа, Дэнжийн мянга, Баянхошуу, Толгойт /5/ дэд төвүүдийн ус хангамжийн системийг найдвартай эх үүсвэрээр хангах зорилгоор дараах ажлуудыг хийхээр төлөвлөсөн. Эдгээр ажлуудыг хэрэгжүүлснээр УСУГ-ын ашиглалтын зардал буурч, Улаанбаатар хотын ус хангамжийн системийн найдвартай ажиллагааг хангах нөхцөл бүрдэнэ.
 - Тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан, баруун дүүргийн насос станц хүртэлх цэвэр ус дамжуулах гол шугамын ажил;
 - Зүүн хойд бүсийн усан сангаас Тасганы усан сан хүртэлх цэвэр ус дамжуулах гол шугамын болон “9Б” бохир ус зайлуулах шугамын ажил.
2. Хөтөлбөрийн III үе шатанд төлөвлөж буй Шархад дэд төвтэй холбох бохир усны шугамын өргөтгөлийн “Улаанбаатар хотын Орос 14-р сургууль орчмын барилга байгууламжийн бохирын татуургын гол цуглуулах шугамын барилга угсралтын ажил” хийгдсэнээр бохир усыг татан зайлуулах нөхцөл бүрдэнэ.

1. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн дугуй резервуарын барилга болон азротанкийн бетон хийцийн шинэчлэлтийн ажил

Хүчин чадал:	Дугуй резервуарын барилга болон Азротанкийн бетон хийцийг засч шинэчлэх; 10.000 диффузор, агаарын шугам селектор суурилуулах;
Гүйцэтгэгч:	“Эс Энд Эй Трейд” ХХК, “Набсан” ХХК-ийн түншлэл
Гэрээний дугаар:	WWTPR01 - Ажлын явц: 100%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	• Барилга угсралтын ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн. • Барилга угсралтын ажил бүрэн дууссан, улсын комисст хүлээлгэн өгөх акт зурагдаж байна.






2. Улаанбаатар хотын Орос 14-р сургууль орчмын барилга байгууламжийн бохирын татуургын гол цуглуулах шугамын барилга угсралтын ажил

Хүчин чадал:	ф400мм-ийн зөөлөн ширмэн ариутгах татуургын шугам - 543м
Гүйцэтгэгч:	“Модерн Хас” ХХК, “Монгол Менежмент Төв” ХХК
Гэрээний дугаар:	WSNR17C - Ажлын явц: 100%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	Барилга угсралтын ажил бүрэн дууссан. 2019.07.16-ны өдөр байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллан 2019/246 дугаар комиссын актаар баталгаажин, байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.



3. Улаанбаатар хотын тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан, баруун дүүргийн насос станц хүртэлх цэвэр ус дамжуулах гол шугамын барилга угсралтын ажил

Хүчин чадал:	ф630мм-н цэвэр ус дамжуулах HDPE хоолой - 8070м
Гүйцэтгэгч:	“Эс Энд Эй Трейд” ХХК, “Набсан” ХХК-ийн түншлэл
Гэрээний дугаар:	WSNR17B - Ажлын явц: 39%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	• 2018 онд цэвэр усны 3 худгийн цутгалтын ажлыг хийсэн. 2019 оны I улиралд барилга угсралтад бараа материалыг нөөцлөх ажлыг зохион байгуулж ажилласан. • ф600мм HDPE шугам суурилуулалт 2300м суурилуулсан. Шугам суурилуулалтын ажил 33%-тай хэрэгжиж байна. • Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлаас шалтгаалан барилга угсралтын ажил удааширч зургийн өөрчлөлтүүд хийгдсэн. • Газар чөлөөлөлт бүрэн хийгдэж дуусаагүй, 89.09%-ийн явцтай байна. • НАЗХГ-тай авто замын холбогдолтой ажлуудад хамтран ажиллах шаардлагатай байна.



4. Улаанбаатар хотын зүүн хойд бүсийн усан сангаас Тасганы усан сан хүртэлх цэвэр ус дамжуулах гол шугамын болон “9Б” бохир ус зайлуулах шугамын барилга угсралтын ажил

Хүчин чадал:	ф900мм-н цэвэр ус дамжуулах HDPE хоолой - 4000м ф600мм-н бохир ус зайлуулах зөөлөн ширмэн хоолой - 1684м
Гүйцэтгэгч:	“Грийн Ресурс Констракшн” ХХК
Гэрээний дугаар:	WSNR17A - Ажлын явц: 25%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	• Цэвэр усны 3 худгийн цутгалтын ажлыг хийсэн. • Барилгын ажилд ашиглагдах бүх бараа материалыг өвлийн улиралд татан авч нөөцлөх ажлыг зохион байгуулсан. • ф900мм HDPE шугам суурилуулалт 480м суурилуулсан. • Газар чөлөөлөлт бүрэн хийгдэж дуусаагүй, 89.09%-ийн явцтай байна. • НАЗХГ-тай авто замын холбогдолтой ажлуудад хамтран ажиллах шаардлагатай байна. Тухайлбал НАЗХГ гүйцэтгэгч байгууллагад шугам суурилуулсан авто замын 1-р эгнээг бус тухайн чиглэлийн бүх эгнээг хучих шаардлага тавьж буйгаас авто замтай хэсэгт шугам суурилуулалтын ажлыг хийж чадахгүй нөхцөл байдал үүсээд байна.



Бүрэлдэхүүн 2. Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд барих

✚ Баянхошуу дэд төвд барих нийгмийн барилга байгууламжууд

Баянхошуу дэд төвд барих 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажил

Хүчин чадал:	2 давхар, 240 хүүхдийн ортой цэцэрлэг, Нийт хэмжээ: 2027.17м2
Гүйцэтгэгч:	“Ус Орчин” ХХК
Гэрээний дугаар:	BSF05, Багц 1 - Ажлын явц: 100%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	- Сонгинохайрхан дүүргийн 8-р хороо, Баянхошуу дэд төвд 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын ажлыг бүрэн дуусгаж, байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллан 2018.12.11-ний өдрийн 2018/737 тоот актаар баталгаажсанаар ашиглагч байгууллага болох Нийслэлийн Боловсролын газарт иж бүрэн тавилга, тоног төхөөрөмжийн хамт хүлээлгэн өгөв. - Сонгинохайрхан дүүргийн 261-р цэцэрлэг нь нийт 345 хүүхэд, 41 багш ажилчидтайгаар үйл ажиллагаа явуулж байгаа ба нийт ажилтнуудын 80% буюу 32 нь Баянхошуу дэд төвийн 32 иргэд байна.





Баянхошуу дэд төвд барих МСҮТ, бизнес инкубатор төвийн барилга угсралтын ажил

Хүчин чадал:	2 давхар, Нийт хэмжээ: 2066м ²
Гүйцэтгэгч:	“Томо Бьюлдинг” ХХК
Гэрээний дугаар:	BSF05, Багц 1 - Ажлын явц: 100%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	- Сонгинохайрхан дүүргийн 8-р хороо, Баянхошуу дэд төвд бизнес инкубатор, сургалт үйлдвэрлэлийн төвийн барилгын ажлыг 2019 оны 03 сард барьж дуусгасан. 2019.06.21-ний өдрийн 2019/200 тоот улсын комиссын актаар баталгаажиж, байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. - Нийслэлийн засаг даргын 2019.08.13-ны өдрийн А/819 тоот захирамжаар ашиглагч, үйлчилгээг хариуцагч байгууллагаар Нийслэлийн Нийтлэг Үйлчилгээний Газар байхаар А/455 тоот захирамжид өөрчлөлт оруулснаар тус барилгыг Нийслэлийн Нийтлэг Үйлчилгээний газарт 2019.11.12-ний өдөр хүлээлгэн өгөв.



Сэлбэ дэд төвд барих нийгмийн барилга байгууламжууд

Сэлбэ дэд төвд барих 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажил

Хүчин чадал:	2 давхар, 240 хүүхдийн ортой цэцэрлэг, Нийт хэмжээ: 2027.17м ²
Гүйцэтгэгч:	“Цаст Констракшн” ХХК
Гэрээний дугаар:	SSF05, Багц 1 - Ажлын явц: 74%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	- Нийслэлийн бүтэц, орон тооны өөрчлөлттэй холбоотойгоор 2019.03.15-ны өдөр хүргүүлсэн барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл 2019.05.07-нд гарсны улмаас барилга угсралт оройтож эхэлсэн. - Барилгын гадна өндөржилтийн ажил, барилгын гадна ариутгах татуурга, усан хангамжийн угсралтын ажил, дээврийн ажил, салхивчны ажил, цонх суулгах ажил, барилгын гадна ханын өрлөгийн ажил тус тус дууссан. - Барилгын гадна болон дотор шавардлагын ажлын гүйцэтгэл - 45%; - Барилгын дотор халаалтын шугам сүлжээ угсралтын ажлын гүйцэтгэл - 65%; - Цэвэр, бохир усны шугам сүлжээний угсралтын ажлын гүйцэтгэл - 50%; - Барилгын дотор цахилгааны шугам сүлжээний угсралтын ажлын гүйцэтгэл - 50%; - Барилгын гадна тохижилтын угсралтын ажил - 60%; - Барилгын гадна хашааны угсралтын ажил - 20%; - Дотор ханын өрлөгийн ажлын гүйцэтгэл - 55% тус тус гүйцэтгэлтэй байна.





Сэлбэ дэд төвд барих МСҮТ, бизнес инкубатор төвийн барилга угсралтын ажил

Хүчин чадал:	2 давхар, Нийт хэмжээ: 2066м ²
Гүйцэтгэгч:	“Бридж Констракшн” ХХК, “Монхас” ХХК-ийн түншлэл
Гэрээний дугаар:	SSF05, Багц 2 - Ажлын явц: 70%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	• Нийслэлийн бүтэц, орон тооны өөрчлөлттэй холбоотойгоор 2019.03.15-ны өдөр хүргүүлсэн барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл 2019.05.07-нд гарсан. • Барилгын сууринд 7 зэргийн хатуу, хадан хөрс гарсан тул суурийн ажлын тоо хэмжээ нэмэгдсэн. • Барилгын гадна өндөржилтийн ажил, барилгын гадна ариутгах татуурга, усан хангамжийн угсралтын ажил, дээврийн ажил, салхивчны ажил дууссан. - Барилгын гадна ханын өрлөгийн ажлын гүйцэтгэл - 98% - Барилгын гадна болон дотор ханын шавардлагын ажлын гүйцэтгэл - 45% - Дотор ханын өрлөгийн ажлын гүйцэтгэл - 60% - Цонх суулгах ажлын гүйцэтгэл - 75% - Барилгын дотор халаалтын шугам сүлжээ угсралтын ажлын гүйцэтгэл - 40% - Цэвэр бохир усны шугам сүлжээний угсралтын ажлын гүйцэтгэл - 40% - Барилгын дотор цахилгааны шугам сүлжээний угсралтын ажлын гүйцэтгэл - 50% - Барилгын гадна тохижилтын угсралтын ажил 60% • Барилгын хашааны угсралтын ажил - 30% тус тус гүйцэтгэлтэй байна.





Бүрэлдэхүүн 3. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын менежментийг бэхжүүлэх

Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ба барилга угсралтын хяналт

Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ (ЗҮ1) нь төслийн үйл ажиллагааны нэн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Тус зөвлөх үйлчилгээний гэрээг 2015 оны 05 дугаар сарын 29-ний өдөр НЗДТГ Солонгосын Дохва Инженеринг ХХК болон Кореа Дүүргийн Дулааны Корпораци, Монконсалт ХХК-ийн Түншлэлтэй байгуулсан. Нийт үнийн дүн 4,024,241.00 ам.доллар бүхий тус гэрээ нь (i) Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах; (ii) Барилга угсралтын ажлын хяналт; (iii) Үе шат 2-ын ТЭЗҮ боловсруулах гэсэн үндсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй.

(i) Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах

Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх Дохва инженеринг компанид төслийн зорилтот хоёр дэд төв (Баянхошуу, Сэлбэ)-ийн инженерийн байгууламжийн нарийвчилсан зураг төслийг боловсруулахад дараах хүндрэлтэй асуудлууд тулгарсан. Үүнд:

1. ТЭЗҮ-д тусгагдсанаар төслийн хүрээнд хийгдэх инженерийн дэд бүтэц нь гэр хорооллын гудамж бүрээр тавигдан өрх айлуудыг холбохоор хийгдсэн нь төслийн хүлээгдэж буй үр дүн болох дэд төвийн хүн амыг 2.5-3 дахин өсгөхтэй нийцэхгүй нөхцөл байдал үүссэн.
2. Гудамж болгоноор өрх айлуудыг дэд бүтцийн шугам сүлжээнд холбоход төслийн төсөвлөсөн зардал хүрэлцэхгүй, нөгөө талаас өрх айлуудын орон сууцны нөхцөлийг сайжруулахгүйгээр шууд холбох боломжгүй.
3. УБ хотын нэгж, хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд зорилтот дэд төвүүдийн инженерийн байгууламжийн хүчин чадлыг тооцохдоо хүн амын өсөлтийг тооцсон тооцоолол, төслийн тооцоолол хооронд зөрүү гарсан.
4. УБ хотын агаарын бохирдлыг бууруулах зайлшгүй шаардлага үүссэнтэй холбоотойгоор дэд төвийн дулаан хангамжийн асуудлыг утаагүй технологи ашиглан шийдэх шаардлага үүссэн.
5. Нөгөө талаар Зөвлөхтэй байгуулсан гэрээ нь цагийн бүртгэлд үндэслэсэн гэрээ бөгөөд ажлын даалгаварт зөвлөхийн бүтээмжийг үнэлэх үнэлгээний асуудал, боловсруулсан зураг төслийг экспертизээр батлуулахтай холбоотой асуудлуудыг хэн хариуцах, хэрхэн шийдвэрлэх зэргийг тодорхой тусгаадаагүй байсан нь ажил удааширахад нөлөөлсөн.

Дээрх шалтгаануудын улмаас инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил нилээдгүй сунжирч хугацаа алдсан ба анхны төлөвлөгөөний дагуу 2016 оны 01 дүгээр улиралд багтаан хүлээлгэн өгөх зураг төслийн хугацааг нийт 6 удаа сунгасны эцэст нарийвчилсан зураг төслийг урьдчилсан байдлаар буюу экспертизийн нэгдсэн дүгнэлтгүйгээр 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдөр ТХН хүлээн авч төслийн худалдан авах ажиллагааг эхлүүлсэн.

Нарийвчилсан зураг төслийг экспертээр батлуулахад газрын гэрчилгээтэй холбоотой асуудал үүссэн ба экспертизийн дүгнэлт гаргуулан магадлан батлуулахтай холбоотой асуудлыг ТХН-ийн зүгээс шийдвэрлэж ажилласнаар Зөвлөх экспертизээр батлагдсан нарийвчилсан зураг төслийн дийлэнхийг батлагдсан төсвийн хамт 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдөр ТХН-д хүлээлгэн өгсөн. Экспертизийн нэгдсэн дүгнэлт гаргуулахад газар чөлөөлөлтөөс үүдэлтэй асуудал тулгарсан нь төслийн хэрэгжилтэд, ялангуяа нарийвчилсан зураг төслийг экспертизээр эцэслэн батлуулах, барилгын ажил эхлэх болон үргэлжлүүлэх зөвшөөрөл авах зэрэгт хүндрэл учруулдаг болох нь төслийн хэрэгжилтийн явцад тодорхой харагдаж байна.

Түүнчлэн, БХБЯ болон НЕТГ-ын өгсөн заавар зөвлөмжийн дагуу Төслийн анхны төлөвлөгөө өөрчлөгдсөнтэй холбоотойгоор төслийн инженерийн байгууламжийн нарийвчилсан зураг төсөл хийх ажлын даалгаварт тусгагдсан ажлын цар хүрээнд өөрчлөлт орсон. Үүний үр дүнд төслийн ажлын цар хүрээнээс Баянхошуу дэд төвийн дулааны шугам сүлжээний, Баянхошуу болон Сэлбэ дэд төвийн цахилгаан, холбооны шугам сүлжээний ажлууд хасагдсан. АХБ-тай зөвшилцсөний үндсэн дээр дулааны шугам сүлжээний өргөтгөлийн ажлын зураг төслийн шууд худалдан авалтаар “Гандирс Од” ХХК-аар ашиглагч байгууллагын хүсэлт, үндэслэлд тулгуурлан хийлгэхээр шийдвэрлэж, зураг төслийг бүрэн боловсруулж дуусгасан. Цахилгаан, холбооны шугам сүлжээ, шинээр тавих дулааны шугам сүлжээний ажлуудыг түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ болгон өөрчилсөн.



Төслийн хүрээнд хийгдэх нийт 24 багц ажлаас 11 ажлын зураг төслийг зөвлөх баг хариуцахаар болсон ба үүний 1 ажил нь түлхүүр гардуулах нөхцөлтэй буюу нарийвчилсан зураг төсөлгүйгээр худалдан авах, үлдсэн 10 ажил нь нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил болж өөрчлөгдсөн. Зөвлөхийн ажлын даалгаварт тусгагдаагүй нийт 13 багц ажлын 5 нь НЗДТГ-ын захиалгаар зураг төсөл хийгдсэн УСҮГ-ын ус хангамж, ариутгах татуургын гол шугамын шинэчлэл өргөтгөлийн ажлууд, 3 нь төслийн хүрээнд 2016 онд бие даасан зөвлөх ажиллуулж боловсруулсан зураг төсөл бүхий бохирын гол коллектор шугамын зураг төсөл, 4 нь түлхүүр гардуулах нөхцөлтэй хийгдэх гэрээ бөгөөд үүнд орлогод нийцсэн орон сууцны туршилтын дэд төсөл хамаарахгүй.

(ii) Барилга угсралтын ажлын хяналт

Зөвлөхийн гэрээний 2-р бүрэлдэхүүн хэсэг болох барилга угсралтын ажлын хяналтыг хэрэгжүүлэх үүргийг уг гэрээний хүрээнд үргэлжлүүлэх эсэхийг гэрээний 1-р бүрэлдэхүүн хэсгийн гүйцэтгэл, гүйцэтгэлийн чанар болон хяналт хэрэгжүүлэх арга зүй, аргачлал болон төлөвлөгөөнд тулгуурлан эцэслэн шийдвэрлэх болзол тавьж Зөвлөх компанитай хэлцэл хийсэн боловч амжилтгүй болсон, мөн зөвлөхийн гэрээний гүйцэтгэл 63.3% бөгөөд зөвлөхийн гүйцэтгэлийг зарцуулсан хугацаанд харгалзуулан үнэлэхэд чанарын хувьд хангалтгүй гэж үзсэн тул зөвлөхийн гэрээг албан ёсоор 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөр дуусгавар болгосон.

Зөвлөх багийн гэрээ дуусгавар болсонтой холбоотойгоор ТХН-ийн зүгээс МУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж буй барилгын тухай хууль болон журмын шаардлагуудыг ханган ажиллах зорилгоор Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраар захиалагчийн хяналт тавиулах саналыг АХБ-ид гаргасан. Уг саналтай холбоотойгоор төслийн хүрээнд НХОГ-ын чадавхын үнэлгээг хийж, тайланг АХБ-ид хүргүүлсэн. Төслийн хүрээнд хийгдэх барилга угсралтын ажлуудыг Захиалагчийг төлөөлөн хяналтыг хэрэгжүүлэх гэрээг АХБ баталгаажуулсанаар НХОГ-тай 2018 оны 5-р сард байгуулсан.

АХБ-ны Худалдан авах ажиллагааны журам болон бусад дотоод холбогдох журмуудад нийцүүлэн, ашиг сонирхлын зөрчилгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Зураг төсөл зохиогчийн хяналтыг олон улсад нээлттэй зарлан зөвлөх сонгон шалгаруулж, 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдөр гэрээ байгуулсан. Улмаар зураг төслийн өөрчлөлтийн улмаас хүлээгдэж байсан ажлууд жигдэрч, шаардлагатай трассын өөрчлөлт бүхий зургийн өөрчлөлтүүд хийгдэж барилга угсралтын ажил хэвийн үргэлжлэх боломжтой болсон.

2019 оны байдлаар захиалагчийн болон зураг төсөл зохиогчийн хяналт хэрэгжүүлээгүй хийж гүйцэтгэсэн барилга угсралтын ажил төслийн хүрээнд байхгүй бөгөөд барилга угсралтын хяналтын ажлууд зохих төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна.

(iii) Үе шат 2-ын ТЭЗҮ боловсруулах

Зөвлөх баг 2017 оны 02 дугаар сард Хөтөлбөрийн 2-р үе шатын ТЭЗҮ-гийн эцсийн тайланг ТХН-ид хүлээлгэн өгсөн. Төсөл 2-ийн ТЭЗҮ-д үндэслэн бэлтгэл хангах ажлыг эхлүүлсэн.

Төслийн хүрээнд хийгдэх зарим ажлын нарийвчилсан зураг төслийг өмнөх онуудад НХОГ-аас хийлгэсэн байсан бөгөөд төслийн явцад шинээр нэмэгдэж буй зарим ажлуудын нарийвчилсан зураг төслийг зөвлөх сонгон шалгаруулан гүйцэтгүүлэх хэрэгцээ гарсан. Иймд, төслийн хэмжээнд Гандирс Од ХХК, Ричвелл инженеринг ХХК, Усны эрчим ХХК, УХАТ ХХК, Архитайп Монголия, Престиж инженеринг зэрэг компаниуд гэрээний дагуу зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.



Хот төлөвлөлтийг сайжруулах, дэд төвийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээ



ЭНГИЙН САЙЖРУУЛАХ
БАГА НЯГТРАЛТАЙ ОРОН СУУЦНЫ БЛОКУУДЫГ
ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ



ЦОГЦООР САЙЖРУУЛАХ
ДУНД НЯГТРАЛТАЙ ХОЛИМОГ АШИГЛАЛТТАЙ
БЛОКУУДЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ



ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ
ӨНДӨР НЯГТРАЛТАЙ ХОЛИМОГ АШИГЛАЛТТАЙ
БЛОКУУДЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хот төлөвлөлтийг сайжруулах, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийг хөгжүүлэх бодлого, журам болон бүтцийг тодорхойлох зорилготой энэхүү зөвлөх үйлчилгээний гэрээг 2015 оны 09 дүгээр сард гэрээ байгуулсан. Тус зөвлөх үйлчилгээ нь иргэдийн оролцоотой дэд төвийн хөгжлийн төлөвлөгөө



боловсруулах, дэд төвийг дахин хөгжүүлэх арга замыг тодорхойлох, хот төлөвлөлт болон газар дахин зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр чадавх бэхжүүлэх гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Тайлангийн хугацаанд үйл ажиллагааны чиглэл тус бүрээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

Иргэдийн оролцоотой дэд төвийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах болон дэд төвийн хөгжлийн арга замыг тодорхойлох

УБ хотыг хөгжүүлэх бодлогын үндсэн баримт бичгүүд болон нэгж хорооллын ерөнхий төлөвлөгөөг зэрэг холбогдох баримт бичгүүдийг судлах, хариуцсан байгууллагуудтай уулзалт хийх, дэд төвийн иргэдтэй зөвлөлдөх уулзалтууд хийх, газар дээр бодит байдлын судалгаа хийх зэргээр ажилласны үр дүнд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн хөгжлийн төлөвлөгөөний анхны хувилбарыг боловсруулж 2017 оны 08 дугаар сард боловсруулсан. Уг төлөвлөгөөнд дэд төвийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, дэд төвийг блокоор хөгжүүлэх концепци, арга зүй, аргачлал, дэд төвийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төлөвлөгөө зэрэг өргөн хүрээг цогцоор нь хамруулсан болно. ТХН болон АХБ-ны холбогдох мэргэжилтнүүдийн санал, зөвлөмжийг тусган засан сайжруулснаар уг төлөвлөгөөг нийслэлийн холбогдох байгууллагууд, хамрах дүүргүүдийн засаг даргын тамгын газрын холбогдох нэгжүүдэд танилцуулах хэлэлцүүлэг уулзалтуудыг зохион байгуулаад байна. Тайлангийн хугацаанд нийт 5 удаа хэлэлцүүлэг уулзалтуудыг хийв. Хэлэлцүүлгийн дүнд гарсан санал, зөвлөмжүүдийг тусган төлөвлөгөөг эцэслэн боловсруулах ажил хийгдсэн.

Уг төлөвлөгөөтэй уялдуулан УБ хотын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол оруулах зайлшгүй шаардлага үүссэн дагуу холбогдох баримтуудыг судалгаа, тооцооллын хамт 2017 оны 03 дугаар улиралд бэлтгэн хүргүүлсэн.

Дэд төвийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзэн дэд төвийн хөгжлийг хангахад дэд төвийн инженерийн байгууламж, нийгэм эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг илтгэх мэдээлэл бүхий газар зүйн мэдээллийн баазтай байгуулах ажлыг зохион байгуулав. Зөвлөх багийн саналын дагуу 2017 оны 07 дугаар сараас эхлэн Баянхошуу, Сэлбэ дэд төвүүд дэх нэгж талбар бүрийн инженерийн байгууламж болон айл өрхийн нийгэм, эдийн засгийн суурь судалгааг засаг захиргааны нэгжүүд болох хэсэг, хорооны холбогдох албан тушаалтнуудаас авч мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэв. Газар зүйн мэдээллийн бааз үүсгэх ажлын хүрээнд дэд төв тус бүрээр 22 төрлийн газрын зураг гаргасан.

Зөвлөх компани эцэслэн боловсруулсан төлөвлөгөөг 2018 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүлээлгэн өгсөнөөр гэрээ дуусгавар болсон. Зөвлөхийн ажил дуусгавар болсоноор ТХН-ид уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх боловсон хүчний асуудал бий болсон. Иймд, Мэргэшсэн мэргэжилтэн зайлшгүй шаардлагатай байгаа хэрэгцээг тодорхойлж санал гаргаснаар НЗДТГ-аас санал оруулж, Сангийн сайдын 2019 оны 72 тоот тушаалаар ТХН-ийн орон тоог Төсөл 2 хэрэгжихтэй холбоотойгоор шинэчлэн баталсан ба үүнд хот төлөвлөлтийн мэргэжилтнийг нэмж оруулсан.

Дэд төвийн хөгжлийн төлөвлөгөөний хэсэг болох блокоор дахин хөгжүүлэх зарчмыг танилцуулах оршин суугчдын зөвлөлдөх уулзалтуудыг туршилт явуулахаар сонгосон нийт 4 блокийн иргэдэд танилцуулж, зөвлөлдөх уулзалтыг 2017 оны 03 дугаар сард нийт 5 удаагийн (Баянхошуу дэд төвд 2, Сэлбэ дэд төвд 3 удаа) уулзалт, 04 дүгээр сард нийт 25 удаа буюу 30 удаагийн уулзалт зохион байгуулсан.

Тайлангийн хугацаанд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор ТХН-ийн зүгээс дараах ажлуудыг хийсэн. Үүнд:

Хот төлөвлөлт болон газар дахин зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр чадавх бэхжүүлэх

Уг бүрэлдэхүүн ажлын хүрээнд хот төлөвлөлт, газар зохион байгуулалт хариуцсан үүрэг чиглэл бүхий нийслэлийн харьяа байгууллагуудыг хамруулан сургалтын хэрэгцээ тодорхойлох судалгааг хийв. ТХН-ээр дамжуулан нийт 15 дэд бүлгийн 74 асуулт бүхий өөрөө өөрийгөө үнэлж тодорхойлох асуулга судалгаанд Нийслэлийн хот төлөвлөлт ерөнхий төлөвлөгөөний газар, Геодези зураг зүйн хүрээлэн, Гэр хорооллын дэд бүтцийн газар, НОСК, НЗДТГ-ын Стратеги, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийслэлийн газрын алба, Барилга, хот байгуулалтын яам, ЭХЯ-ны стратеги, бодлого төлөвлөлтийн газар зэрэг байгууллагууд хамрагдав. Сургалтын хэрэгцээ тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулах ажил 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс эхэлж 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр дууссан. Үүнд нийт 11 байгууллага оролцохоос 8 нь мэдээллээ бүрэн өгсөн бөгөөд 3 байгууллага оролцохоос татгалзсан. Нийт 8 байгууллагын 76 албан хаагчаас мэдээлэл цуглуулж, судалгааны мэдээлэлд үндэслэн сургалтын хөтөлбөр, агуулгыг тодорхойлон чадавх бэхжүүлэх хөтөлбөр боловсруулав.



2018 онд холбогдох байгууллагын удирдлагуудад судалгааны дүн, сургалтын хөтөлбөрийг танилцуулан 8 удаа уулзалт зөвлөгөөн хийсэн ба сургалтад хамрагдах мэргэжилтнүүдийн нэрсийг гаргуулан нийт 3 долоо хоногийн 44 цагийн сургалт зохион байгуулж хамруулсан. Сургалтын сэдэв болон оролцогчдын талаарх мэдээллийг Хавсралт 4-т үзүүлэв.

✚ **Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг чадавхжуулах**

Тайлангийн хугацаанд CSOI дугаартай “Хотын үндсэн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаа, менежментийг сайжруулах болон байгууллагын болон эрх зүйн шинэчлэлийг дэмжих” зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг гүйцэтгэн, гэрээний хэлэлцээрийг амжилттай зохион байгуулж, 2019 оны 12-р сарын 20-ны өдөр гэрээ байгуулав. Уг зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг НХААГ зохион байгуулж гүйцэтгэсэн бөгөөд сонгон шалгаруулалтыг эцэслэхэд нийт 1123 хоног зарцуулсан байна.

Үзэглэсэн гэрээг АХБ баталгаажуулан зөвшөөрөл ирүүлснээр Зөвлөхөд албан бичгээр мэдэгдэн зөвлөх үйлчилгээний ажлыг 2020 оны эхний улиралд эхлүүлнэ.

✚ **УСУГ-ыг дэмжих үйл ажиллагаа**

Гүйцэтгэгч:	“Комфорт Импекс” ХХК, "Хунан Шиангнү Энвайронментал Протекшн Индустриал" ХХК-иудын түншлэл
Гэрээний дугаар:	WWOI – Ажлын явц: 100%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	- Барилга угсралтын ажил бүрэн дууссан. 2018.11.28-ны өдөр байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллан 2018/650 дугаар комиссын актаар баталгаажиж, байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. - Ашиглагч байгууллага нь “Ус Сувгийн Удирдах Газар” ОНӨААТҮГ.

УСУГ-ын үйл ажиллагааг сайжруулах дэд төслийн хүрээнд Үйлдвэр, Мах, Төв болон Гачуурт насос станцуудад тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, түгээх сүлжээний удирдлагын болон хэмжих худгуудын барилга угсралт, УСУГ-ын удирдлагын төвд СКАДА систем, усны алдагдлыг илрүүлэх систем суурилуулах, нэгдсэн удирдлагын програм хангамжийг ажлыг гүйцэтгэн ашиглалтад оруулах зэрэг ажлуудыг 100% хийж гүйцэтгэсэн. Үүнд шаардлагатай нийт 39,700м урт шилэн кабель суурилуулах ажлыг бүрэн хийж дуусгасан. Үйлдвэрийн станцын удирдлагын системийг ашиглалтад оруулж ажиллагааг жигдрүүлснээр 1 ба 2-р өргөгчийн насос станцыг хянан удирдаж хяналтын хаалт угсралтын шинэчилсэн графикийг холбогдох хүмүүсээр батлуулан ажиллаж байна. Тус дэд төслийн хүрээнд дараах дэд ажлуудыг бүрэн хийж дуусгасан. Үүнд:

- Ус хангамжийн эх үүсвэрүүдэд насосын давтамж хувиргагч, шилэн кабель, өргөлтийн насосууд суурилуулж автоматжуулалт хийгдсэн.
- Ус хангамжийн шугам сүлжээнд хэмжилтийн 40 худгийн 30 худгийг шинээр барьж, 10 худгийг шинэчлэн засварласан.
- Төв цэвэрлэх байгууламжийн СКАДА программ, шилэн кабелийн суурилуулалтыг хийж гүйцэтгэсэн.

Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй уг дэд төслийн хүрээнд Төвийн эх үүсвэрийн 6кВ-ын 750кВт-ын хүчин чадал бүхий цахилгаан хөдөлгүүрт Harvest Schneider брэндийн давтамж хувиргагч суурилуулснаар 3 насос хөдөлгүүрийг удирдан ажиллуулах бүрэн боломжтой болсон.





Давтамж хувиргагчийн ерөнхий удирдлагын дэлгэц дээр үндсэн үзүүлэлт болон шаардлагатай параметрууд гардаг бөгөөд насос болон цахилгаан хөдөлгүүрийг гаралтын шугам дээр тавигдсан даралтын мэдрэгчийн мэдээллээр удирдан ажиллуулж байна. Энэхүү ухаалаг төхөөрөмж нь дэлгэц дээр шаардлагатай байгаа даралтыг өгснөөр уг тоноглол өгөгдсөн утгыг барьж ажилладаг тул усны алдагдлыг бууруулахад чухал ач холбогдолтой.

1м³ ус олборлон түгээхэд зарцуулж буй цахилгаан эрчим хүч /Төв станц/


Сар	2015	2016	2017	2018
1	0.72	0.70	0.76	0.65
2	0.71	0.75	0.67	0.59
3	0.68	0.64	0.68	0.55
4	0.60	0.68	0.55	0.49
5	0.80	0.60	0.61	0.53
6	0.62	0.69	0.62	0.46
7	0.61	0.60	0.59	0.55
8	0.60	0.64	0.59	0.51
9	0.69	0.67	0.52	0.41
10	0.62	0.59	0.54	0.45
11	0.68	0.74	0.55	0.37
12	0.65	0.55	0.56	
	0.66	0.65	0.61	0.51

Тайлбар: Хэмжих хэрэгсэл болон электрон тоолуураар гарсан тоон үзүүлэлт

Тус дэд төслийн хүрээнд давтамж хувиргагчийг суурилуулсан нь Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд дөхөм болсон. Давтамж хувиргагчийг суурилуулснаар өмнөх 3 жилийн дунджаар 1м³ усыг 0,64кВт/цаг эрчим хүчээр олборлон түгээдэг байсан бол 2018 онд 0,51кВт/цаг болж 0,12кВт/цагийн эрчим хүчээр буурч эрчим хүчний хэмнэлттэй ажиллаж эхэлсэн байна.

Автоматжуулалтын ажил: УСУГ-ын ус хангамжийн 4 эх үүсвэрийн станцуудын алсын удирдлагын шилэн кабель, холболтын төхөөрөмжүүдийг суурилуулах ажил бүрэн дууссан. Тухайлбал, УСУГ-ын шинээр баригдсан төв оффисын барилгад нэгдсэн удирдлагын төв, диспетчерийн дэлгэцийг суурилуулсан ба диспетчерийн өрөөнөөс хянан ажиллаж байна. Эрчим хүчний хэмнэлттэй орчин үеийн шаардлагад нийцсэн цахилгаан тоног төхөөрөмж нэвтрүүлэн ус хангамжийн эх үүсвэрүүдэд насосын давтамж хувиргагч, шилэн кабель, өргөлтийн насосууд суурилуулж автоматжуулалт хийж, ус

хангамжийн шугам сүлжээнд хэмжилтийн 40 худгийн 30 худгийг шинээр барьж, 10 худгийг шинэчлэн засварлан Төв цэвэрлэх байгууламжийн шилэн кабелийн суурилуулалтын ажлыг SCADA системийн хамт хийж гүйцэтгэсэн. Ингэснээр эрчим хүчний хэрэглээ буурч 0,12кВт/цагийн хэмнэлттэй ажиллаж эхэлсэн.



Махын эх үүсвэрийн станц



Гачууртын эх үүсвэрийн станц



Үйлдвэрийн эх үүсвэрийн станц



Бүрэлдэхүүн 4. Институцийг хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх

Төслийн удирдлагын дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

Төслийн удирдлагын дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээг 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Франц улсын Эжис Интернэйшнл компанитай байгуулсан. Гэрээний нийт хугацаа 36 сар бөгөөд зөвлөх үйлчилгээний зорилго нь төсөл хэрэгжүүлэх нэгжийн Төсөл 1-ийг АХБ болон МУ-ын Засгийн газрын холбогдох дүрэм журмын дагуу хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх юм. Зөвлөхийн ажил нь:

- Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг чадавхжуулах
- Хөтөлбөрийн санхүүгийн менежментийн тогтолцоог бий болгон, цахим бүртгэлийн системийг бүрэн нэвтрүүлэх
- Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө, жөндөрийн төлөвлөгөө болон нийгмийн хамгааллын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих
- Худалдан авах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
- АХБ-ны хамгааллын бодлогын дагуу холбогдох бичиг баримт, төлөвлөгөө зэргийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд ТХН-ийн ажилтнуудын чадавхыг бэхжүүлэхэд ажлыг байрны сургалт болон албан сургалт гэсэн 2 хэлбэрээр зохион байгуулсан. Албан сургалтын хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, MS Project програм, АЗ сертификат олгох сургалт, АХБ-ны худалдан авах ажиллагааны журам, АХБ-ны хамгааллын бодлого ба түүнийг хэрэгжүүлэх (нийгмийн хамгаалал, байгаль орчин ба аюулгүй байдал, газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлт), Албан бичиг хэрэг хөтлөлт ба архив, Цагийн менежмент, Багийн ажиллагаа, Байгууллагын ёс зүй, Харилцааны ур чадвар, Асуудлыг шийдвэрлэх чадвар зэрэг сэдвүүдийн хүрээнд багц сургалтуудыг зохион байгуулсан.

Дээрх албан сургалтуудаас гадна ажлын байран дахь сургалтыг барилга угсралтын ажлын гэрээний удирдлага болон түлхүүр гардуулах гэрээний удирдлага сэдвээр олон улсын зөвлөхийн удирдлага дор зохион явуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих холбогдох ажилтнуудыг хамруулав. Мөн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн асуудлаар НЗДТГ-ын түвшинд холбогдох албаны хүмүүс, мэргэжилтнүүдийг хамруулан семинар зохион байгуулсан.

ТХН-ийн санхүү бүртгэл, тайлагналын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зах зээлд өргөн хэрэглэгдэж буй туршигдсан програм хангамжийг худалдан авч хэрэглээнд нэвтрүүлсэн. Уг програмын тусламжтайгаар ТХН-ийн санхүүгийн тайлангуудыг илүү үр ашигтай, холбогдох байгууллагуудын шаардлагад нийцүүлэн цаг алдалгүй хугацаанд нь тайлагнах боломж бүрдсэн. АХБ-ны санхүүгийн менежментийн бодлого, журмын талаар ажлын байранд дагалдан сургах ажлыг хийсэн ба тухайн он тус бүрээр санхүүгийн төсөөллийг гаргаж, төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэн ажиллав.

ТХН-ийн худалдан авах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд ТХН-ийн худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэнд мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажиллав. Үүнд НХААГ-аас ирүүлсэн тендерийн үнэлгээний тайланг холбогдох журам болон ТББ-г заасан шаардлагуудын дагуу үнэлсэн эсэхийг хянан нягтлах, АХБ-ны тендерийн үнэлгээний тайланд өгсөн асуулга, тодруулгын дагуу холбогдох тайлбарыг нотлох баримтуудын хамт бэлтгэн хүргүүлэх, тендерийн үнэлгээний тайланг эцэслэхэд дэмжлэг үзүүлэх зэргээр ажиллав. Мөн ТХН-ийн бэлтгэсэн тендерийн баримт бичгийг хянан тохиолдуулах, АХБ-наас ирүүлсэн заавар, зөвлөмжийн дагуу засаж сайжруулах, холбогдох дүрэм журмын дагуу тайлбар хийх зэрэгт ТХН-ид дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

АХБ-ны хамгааллын бодлогын дагуу хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагуудаар хянуулж батлуулахтай холбоотойгоор төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг шинэчлэх ажлыг гүйцэтгэх зөвлөх сонгон шалгаруулахад дэмжлэг үзүүлэн зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулан хүлээлгэн өгсөн. НХААГ-аас зөвлөх сонгон шалгаруулах ажлыг эхлүүлж, хамгийн сайн үнэлгээ авсан компаниар “Экопланет” ХХК шалгарсан гэрээ байгуулах зөвлөмж бүхий тендерийн үнэлгээний тайланг 2017 оны 12 дугаар сард гаргасан ба 2018 оны 01 дүгээр улиралд багтаан гэрээ байгуулж ажил эхлүүлэхээр болсон. Түүнчлэн АХБ-тай байгуулсан зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүрэг, амлалтуудыг биелүүлэх хүрээнд байгаль орчны хөндлөнгийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулсан. Тус хөндлөнгийн хяналтын зөвлөхөөр “Сошио Энвайронментал Сервис” ХХК шалгаран 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан.



ТХН-ийн 2017 онд байгуулсан нийт 12 ширхэг барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ тус бүрээр гүйцэтгэгчийн боловсруулж төслийн менежерээр батлуулах Гүйцэтгэгчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянахад ТХН-ид мэргэжлийн тусалцаа үзүүлэн ажилласан.

АХБ-ны хамгааллын бодлогын дагуу төслийн нийгмийн үйл ажиллагааны болон жендэрийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, нөлөөлөлд өртөж буй иргэдтэй ганцаарчилсан ярилцлага хийх замаар мэдээлэл цуглуулах, оршин суугчдын зөвлөлтэй хамтран эдгээр төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх уулзалтууд зохион байгуулах зэргээр ТХН болон дэд төвийн оршин суугчидтай нягт хамтран ажиллав.

Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулах, АХБ-аар батлуулах, шаардлагатай тохиолдолд газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэргээр ТХН-ийн мэргэжилтнүүдтэй тогтмол хамтран ажилласан.

Зөвлөх баг үүргийн дагуу гэрээт ажлуудыг гүйцэтгэн эцсийн тайлангаа 2018 оны 12 дугаар сард хүлээлгэн өгснөөр гэрээ дуусгавар болсон.

Зөвлөхийн бий болгосон тогтолцоог цаашид бэхжүүлэн төслийн удирдлагыг сайжруулах зорилгоор төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс 2019 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд: Төсөл 2 эхэлсэнтэй холбогдуулан шинээр нэмэгдсэн ажлын байранд мэргэжилтнийг АХБ-ны журмын дагуу сонгон шалгаруулж, холбогдох зөвшөөрлийг авах, төслийн хэрэгжилтийн явцыг хэмжих тогтолцоог бий болгон тогтмол сарын давтамжтайгаар удирдлагад танилцуулах дотоод тогтолцоог бий болгох хэвшүүлэх, худалдан авах ажиллагааны баримт бичгийг хянах давхар тогтолцоог бий болгох, санхүүгийн тайлагналын тогтолцоог сайжруулах, байгууллагын цахим хуудсыг шинэчлэн мэдээллийг иргэдэд нээлттэй хүргэх тогтолцоог хэвшүүлэх, олон нийтийн сүлжээ ашиглан төслийн талаар иргэд, олон нийтэд үнэн зөв мэдээлэл хүргэн дэмжлэг авах, сар бүр тайлагнах тогтолцоог бий болгосноор төслийн оролцогч талуудад цаг тухайд нь төслийн явцын талаар тайлагнан мэдээлэх, барилга угсралтын гэрээнүүдийн хэрэгжилтийн явцыг хянах, гаалиар орж ирж буй бараа материалыг чөлөөлүүлэх ажлыг хөнгөвчлөн цаг хугацаа хэмнэсэн хэрэгслийг хэрэглэж хэвшүүлэх, гүйцэтгэгч байгууллагуудаас ажлын төлөвлөгөөг гэрээнд заасан хугацаанд багтаан тодотгуулан авч хянан ажиллах, асуудлыг хяналт хэрэгжүүлэгч болон ашиглагч байгууллагуудтай хамтран тухай бүрт нь хэлэлцэн шийдвэрлэх, уулзалт хэлцлүүдийн тэмдэглэлийг цаг тухайд нь боловсруулж баримтжуулах ажлуудыг хэвшүүлэн ажилласан.

Иргэд, олон нийтийн оролцоог хангах болон ЖДҮ-ийг хөгжүүлэх

Хөтөлбөрийн I үе шатны Баянхошуу, Сэлбэ дэд төвийн иргэд, олон нийтийн оролцоог хангах, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх гэрээг НҮБ-ын Хабитат олон улсын байгууллагатай 2015 оны 07-р сард байгуулснаар зөвлөх баг 2018 оны 12-р сарын 31 хүртэл ажилласан. Гэрээний хугацаанд зөвлөх баг нь Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд иргэдийн оролцоог хангах зорилгоор оршин суугчдын хошуучлалтай “Ард Түмний үйл ажиллагаа” олон улсын аргачлалыг нэвтрүүлэн, анхан шатны оршин суугчдаас бүрдсэн анхдагч бүлэг, анхдагч бүлгийн ахлагч, нарийн бичгээс бүрдсэн хорооны оршин суугчдын зөвлөл, хорооны оршин суугчдын төлөөллөөс бүрдсэн дэд төвийн оршин суугчдын зөвлөл гэсэн 3 шатлалтайгаар орон нутгийг зохион байгуулж, иргэдэд тогтмол мэдээллийг хүргэж, төслийн үйл ажиллагаанд иргэдийн дуу хоолой, идэвхтэй оролцоог хангаж ажиллав.

Гэрээний хугацаанд төслийн хүрээнд Сэлбэ дэд төвд 717 гишүүнтэй 70 анхдагч бүлэг, 129 гишүүнтэй 3 оршин суугчдын зөвлөл, Баянхошуу дэд төвд 989 гишүүнтэй 90 анхдагч бүлэг, 162 гишүүнтэй 5 хорооны оршин суугчдын зөвлөл, 18 гишүүнтэй 1 дэд төвийн оршин суугчдын зөвлөлийг зохион байгуулсан. Эдгээр оршин суугчдын анхдагч бүлгүүдийг дэмжин зохион байгуулалтад оруулснаар тэдгээрийг нэгтгэсэн, анхдагч бүлгүүдийн төлөөлөл бүхий Баянхошуу дэд төвд 1, Сэлбэ дэд төвд 2 (Сүхбаатар дүүрэг, Чингэлтэй дүүрэг) оршин суугчдын зөвлөл болох төрийн бус байгууллагууд бий болж дэд төвийн хөгжлийн явцад хуулийн этгээдээр хувиар оролцох боломж бий боллоо.

Мөн дээрх оршин суугчдын зөвлөл болон анхдагч бүлгүүдийг чадавхжуулах ажлын хүрээнд нийт 11 төрлийн чадавхжуулах арга хэмжээ зохион байгуулж үүнд гишүүдийн 67.5% буюу нийт 209 гишүүдийг хамруулав. Эдгээр арга хэмжээ нь оршин суугчдын байгууллагуудыг байгууллагын хувьд бэхжүүлэх, хооронд нь холбож оршин суугчдын анхдагч бүлгүүдийн сүлжээ үүсгэх, орон нутгийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, бүлгийн гишүүдийг ажилд зуучлах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн болно.



Оршин суугчдын зөвлөлийн үйл ажиллагаа идэвхжиж байгааг илтгэх нэг үзүүлэлт нь гишүүдийн тоо нэмэгдэх ба 2015-2019 онуудын өсөлтийг доорх хүснэгтэд харуулав.

Оршин суугчдын байгууллага		2015	2016	2017	2018/2019
Баянхошуу дэд төв	Анхдагч бүлгийн тоо	9	27	29	90
	Анхдагч бүлгийн гишүүд	274	448	466	989
	ОСЗ-ийн тоо	6	6	6	6
	Гишүүд	36	72	76	162
Сэлбэ дэд төв	Анхдагч бүлгийн тоо	14	29	31	70
	Анхдагч бүлгийн гишүүд	172	371	443	717
	ОСЗ-ийн тоо	2	2	2	3
	Гишүүд	28	58	62	129

Оршин суугчдын зөвлөл, бизнесийн зөвлөлүүд нэгдэн төрийн бус байгууллага болж байгаа бөгөөд 3 ТББ байгуулагдсан.

Нийслэл, дүүрэг, хороодын удирдлагууд, албан хаагчид, дэд төвийн иргэд, оршин суугчдад 249 уулзалт болон үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 6647 хүнд Баянхошуу, Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалтын явцын танилцуулга хийж, иргэдийн дуу хоолойг сонсож, тухай бүрт бүтээн байгуулалтын ажилд иргэдийн санал бодол, орон нутгийн хэрэгцээг тусгаж хамтран ажиллаа.

ТХН-ийн болон зөвлөх багийн мэргэжилтнүүд, орон нутгийн иргэд, оршин суугчдын зөвлөлийг чадваржуулах сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулсан бөгөөд 26 сургалтыг 920 хүнд хийж, иргэдийн оролцооны байгууллага, багийн ажиллагаа, харилцаа холбоо тогтоох, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, хамтын ажиллагаа түншлэл, болон хяналт үнэлгээ, төлөвлөгөө болон оршин суугчдын зөвлөл, дэд төвийн оршин суугчдын зөвлөлийг удирдлага, менежмент, бичиг баримт боловсруулах болон төрийн бус байгууллага, түүний тогтвортой байдал, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах гэх мэт сургалтуудад хамруулж чадваржууллаа. Чадваржсан иргэд, гишүүд төслийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллаж, иргэдтэй зөвшилцөл хийх, мэдээлэл хүргэх, хэрэгцээтэй судалгааг авах, газар чөлөөлөлтөд иргэдийн оролцоог хангах гэх мэт ажлуудад дэмжлэг үзүүлэн, иргэд болон төслийн гүүр болж хамтран ажиллалаа. Үүнд оршин суугчдын зөвлөлтэй хамтран нөлөөлөлд өртсөн 1325 иргэнтэй зөвшилцөх 51 уулзалтыг зохион байгуулсан.

Мөн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд иргэдийн оролцоог хангах үүднээс Сэлбэ дэд төвд баригдах дулааны станцын байршил орчмын оршин суугч иргэдтэй уулзалтууд хийсэн ба үүнд нийт 89 иргэн оролцсоны 57% нь эмэгтэйчүүд байв.

Иргэд, оршин суугчидтай бүлгээр болон ганцаарчилсан уулзалтуудыг зохион байгуулахад Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийн оршин суугчдын зөвлөл, анхдагч бүлгүүдийг татан оролцуулж, тэдний дэмжлэгтэйгээр иргэдийг ухуулах, төслийн үйл ажиллагааг дэмжин оролцоход уриалах зэргээр хамтран ажиллав.

Тус зөвлөх багийн бий болгосон иргэдийн бүлгүүдэд түшиглэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн баг Төсөл 2-ын зөвлөх багтай хамтран 2019 онд Баянхошуу, Сэлбэ дэд төвийн хороодын иргэд, оршин суугчид, оршин суугчдын зөвлөлийн гишүүдэд явцын танилцуулга уулзалтууд тогтмол зохион байгуулагдсан ба нийт 23 удаагийн уулзалтаар 989 иргэнд мэдээлэл хүргэсэн байна.

Анх удаа иргэд, оршин суугчдад дараагийн түвшний мэдлэг, мэдээлэл хүргэж, дуу хоолойг нь сонсох зорилгоор “Иргэдийн оролцоо-Дэд Төвийн Хөгжилд” 2 өдрийн хэлэлцүүлэг-семинар Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдэд зохион байгуулагдаж, хороодын засаг дарга, хэсгийн ахлагчид, оршин суугчид болон бизнесийн зөвлөл болон иргэдийн төлөөлөл нийт 169 хүн оролцлоо. Хэлэлцүүлгийн үеэр Баянхошуу, Сэлбэ дэд төвийн байгуулалтын ажлын хүрээнд хийгдсэн ажлууд болон цаашид иргэдийн оролцоотойгоор дэд төвийг хөгжүүлэх үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах талаар иргэдийн санал бодлыг сонсож, бүлгийн ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүллээ. Уг арга хэмжээнд АХБ, НОСК ХК, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг

(GIZ), НҮБ-ын ХАБИТАТ байгууллага, “Юу Си Ди” ХХК, “Хот байгуулалтын мэдээлэл судалгааны төв” ТББ, Баянхошуу дэд төвийн Оршин суугчдын зөвлөл, Бизнесийн зөвлөл, “LAB2” ТББ, “Монголын урлагийн зөвлөл” –ийн төлөөллүүд оролцож, дэд төвийн хөгжилд иргэдийн оролцоо, түүний хууль эрхзүйн орчин, хүн төвтэй хот төлөвлөлт, хотыг хөгжүүлэх төслүүдийн олон улсын жишээ, Монгол улсад хэрэгжсэн хот шинэчлэлтийн төслүүдийн алдаа ба сургамж, хотыг шинэчлэхэд хувийн хэвшлийн байгууллагууд, ТББ-уудын хэрэгжүүлсэн ажлын туршлагууд, иргэдийн хуримтлалын бүлэг байгуулсан туршлага, иргэдийг чадавхжуулах зорилгын хүрээнд жижиг дунд бизнесийг хөгжүүлэх арга зам, иргэдэд зориулсан ур чадварын сургалтын талаар мэдээлэл өгч, хотыг дахин хөгжүүлэх хувилбаруудыг танилцуулж, тэдгээр хувилбаруудыг хэрэгжүүлэхэд иргэд хэрхэн оролцох талаар хэлэлцүүлгийг хийлээ. Үүний дараа “Иргэдийн оролцоо-дэд төвийн хөгжилд” салбар уулзалтуудыг дэд төв тус бүр дээр бямба гараг бүр зохион байгуулж байна.



Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээ, нийгмийн байгууламжийн бүтээн байгуулалт явагдаж байгаатай холбогдуулан 2019 оны 12 сарын 25-ны байдлаар Өргөдөл гомдол 39 (11-Баянхошуу, 28-Сэлбэ) өргөдөл ирснээс газрын үнэлгээ, нөхөн олговортой холбоотой-20, барилгын явц-7, бүтнээр хамрагдах хүсэлтэй-1, цэцэрлэгт хүүхдээ хамруулах хүсэлт-1, газар эзэмших хүсэлт-1, тодорхойлолт авах-1, ажилд ороход туслах-1, нөхөн сэргээлттэй холбоотой 7 өргөдөл гомдол ирсэн бөгөөд бүгд хугацаандаа шийдвэрлэгдсэн.

Нийгмийн төсөл хөтөлбөрүүд

ТА-9421: Мэдээллийн технологийг ашиглан гэр хорооллын иргэдэд мэдээлэл хүргэх төсөл

2017 онд АХБ-ны Дунд шатны үнэлгээний явцад Мэдээлэл технологид суурилсан төслийн мониторингийн цахим хэрэгслийг бий болгох бөгөөд дэд төвийн иргэдийг мэдээллээр хангах талаар санал тавьсныг сайшаан дэмжиж уг ажлыг хэрэгжүүлэхэд зориулсан 500,000 ам.долларын буцалтгүй тусламж үзүүлэх болсон.

Мэдээлэл холбооны технологийг ашиглан гэр хорооллын иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор 2018 оны 5-р сараас 2019 оны 12-р сар дуустал хэрэгжүүлж буй энэхүү төслөөр 4 зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

Зорилт 1. Баянхошуу, Сэлбэ дэд төвийн хэмжээнд хот төлөвлөлт, орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан нийгэм эдийн засгийн судалгаа явуулж, судалгаанд дэд төвд буй хашаанд амьдарч буй өрх бүрийг хамруулан мэдээллийн сан үүсгэн газарзүйн мэдээллийн системтэй холбон мэдээллийн бааз бий болгосон. Энэхүү мэдээллийн бааз нь хот төлөвлөлтийг мэдээлэлд суурилж хийх боломжийг мэргэжлийн байгууллагуудад бий болгохоос гадна хөгжлийн үйл ажиллагаанд оролцох иргэдэд мэдээлэл авч идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлж байгаа юм. Нийгэм эдийн засгийн судалгаанд Баянхошуу дэд төвийн нийт 3466 өрх, 3549 хашаа, 3372 байшин, Сэлбэ дэд төвийн 2420 өрх 2378 хашаа, 2171 байшин хамрагдсан болно. Газарзүйн мэдээллийн санг хот төлөвлөлт, дэд төвийг хөгжүүлэхэд уялдуулахын тулд Баянхошуу дэд төвийн 3765 нэгж талбар, Сэлбэ дэд төвийн 2420 нэгж талбарыг кодолж, Баянхошуунд 33, Сэлбэд 30 газар ашиглалтын чиг үүргийн бүсээр нэгтгэн, судалгааны үр дүнг гаргаж мэдээллийн сантай болгосон. Уг мэдээллийн сангаас холбогдох хэсгийн мэдээллийг НОСК-ийн хүсэлтээр Орлогод нийцсэн ногоон орон сууцны төслийн нэгжид гарган өгч дэмжин ажиллаж байна.



Зорилт 2. Иргэдийн оролцоог хангах, иргэдийг идэвхжүүлэх зорилгоор “Миний гэр-Миний хот” хөтөлбөрийг Монголын Урлагийн Зөвлөлтэй хамтран Сонгинохайрхан дүүргийн 7, 8, 9, 10, 28-р хороонд 2019 оны 4 сараас эхлэн хэрэгжүүллээ. Хөтөлбөрийн хүрээнд:


- “Хог болгон хог биш!” дахивар хог хаягдлаар гар урлалын бүтээл хийх 3 сарын сургалтад СХД-ийн 67, 76, 105 дугаар сургуулийн 90 сурагчийг хамруулан, уран бүтээлч сэтгэлгээ, байгаль орчин-ногоон хөгжлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэн ажиллав. Сургалтыг хороо, ЕБС-ийн багш удирдлагуудтай хамтран 9 мэргэжлийн зураач, дизайнерууд удирдан чиглүүллээ. Сурагчид өөрсдийн бүтээсэн 200 гаруй бүтээл бүхий хамтарсан үзэсгэлэнг хорооны иргэдэд танилцууллаа.



- “Re-Imagine Ulaanbaatar” цаасан шуумал урлалын аргаар бэлэг дурсгалын бүтээл туурвих 3 сарын сургалтыг 261 дүгээр цэцэрлэгийн 20 багш, ажилтнууд болон хорооны ээж нарыг хамруулан амжилттай зохион байгуулж, 50 гаруй бүтээлээр үзэсгэлэн гаргав. Шилдэг,

шаардлага хангасан гар урлалын бүтээлүүдийг www.redger.org цахим худалдааны сайтаар дамжуулан борлуулах боломжийг сургалтад оролцогчдод олгосон.

- Орчин үеийн техник технологийг ашиглан иргэдэд өөрсдийн хэрэгцээт мэдээллийг виртуал орон зайгаар хүргэх, мэдээлэл олж авах системийг бүрдүүлж “Шинэ дэд төв” вебсайтыг хөгжүүлж байна.
- Баянхошуу дэд төвийн бүтээн байгуулалтын ажлын нэг хэсэг болох үерийн хамгаалалтын сувгийн ажил дууссантай холбогдуулан хамгаалалтын суваг дагуух 144 айлыг хамруулан хог хаягдлын менежментийн судалгааг Сонгинохайрхан дүүргийн 9, 10, 28 дугаар хорооны нутаг дэвсгэрт явуулсан. Судалгаагаар иргэд хогны машин хэзээ ирэхийг мэддэггүйгээс хогоо хашааны гадаа тавих явдал хамгийн түгээмэл байгааг илрүүлсэн. Иргэдийн санал, судалгааны дүгнэлтийг нэгтгэн хороо, хэсгийн удирдлага, дүүргийн тохижилт үйлчилгээний газар, ТҮК-ийг байлцуулан хогны машин ирэх, хог ачих хуваарийг оруулах гар утасны аппликейшн боловсруулах санааг гаргасныг дэмжин гар утасны аппликейшн боловсруулж, нийтийн хэрэглээнд гаргахад бэлэн болгосон. Уг аппликейшний туршилтын хувилбарыг танилцуулан санал авах уулзалтуудыг хийхэд иргэд нэн сайшаалтай хүлээн авч байв.



Зорилт 4. Жижиг дунд бизнесийг дэмжих чиглэлээр бизнесийн төлөвлөгөө боловсруулан ажлын байрыг нэмэгдүүлэх мэдээллийг иргэдэд хүргэх 10 төрлийн цахим гарын авлагыг виртуал платформд байрлуулан ажиллаж байна. Түүнчлэн Хөдөлмөр Халамжийн Үйлчилгээний Ерөнхий газартай санамж бичиг үйлдэн тэдний ажлын байрны зар мэдээг гэр хорооллын иргэд авах боломжийг нээж виртуал платформ дээр холболт хийж, иргэд хүссэн ажлынхаа зарыг түргэн шуурхай нэг цэгээс авах боломжийг нээж өглөө.

Зорилт 4. Виртуал платформ үүсгэж төслийн газарзүйн мэдээллийн сан болон шинэ дэд төв вебсайтыг иргэдэд нээлттэй ашиглах боломжийг бүрдүүлсэн. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдэд хэрэгцээтэй мэдээлэл хүргэх зорилгоор Баянхошуу Бизнес Инкубатор төвд “Иргэдийн мэдээллийн төв”-ийн өрөөг шаардлагатай техник хэрэгсэл, тавилга төхөөрөмжөөр тоноглон иргэдэд нээлттэй мэдээллийн төвийг нээхэд бэлэн болголоо. Иргэдийн мэдээллийн төвд бичил номын сан байгуулах ажлыг санаачлан хандивын аян зохион байгуулан одоогоор 1000 орчим ном цуглуулаад байна.

ТА-9528: Азийн Хөгжлийн Банкны санхүүжилттэй өрхийн амьжиргааг дэмжих техникийн тусламжийн хөтөлбөр

Уг хөтөлбөр нь Баянхошуу, Сэлбэ дэд төвийн инженерийн шугам сүлжээ болон нийгмийн байгууламжийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд өртсөн зорилтот бүлгийн болон өрхийн бизнес эрхлэгч өрхүүдийн амьжиргааг дэмжих, нөхөн сэргээх зорилготой загвар төсөл бөгөөд 2018 оны 6-р сараас 2019 оны 11 дүгээр сарыг дуустал 2 үе шаттай хэрэгжиж нийт 96 өрхөд дэмжлэг үзүүлсэн байна. Төслийн хүрээнд нийт 237 өрхийг судалгаанд хамруулж үүнээс 96 өрхийг сонгон дэмжлэг үзүүлсэн.


1-р үе шатанд нөлөөлөлд өртсөн нэн эмзэг, зорилтот бүлгийн 44 өрх хамрагдаж, үүнээс 40 иргэн мэргэжлийн болон жижиг бизнес эрхлэх сургалтад хамрагдаж мэргэжил, ур чадвараа ахиулсан. Мөн 20 өрх өрхийн бизнес эрхлэх тоног төхөөрөмжийн дэмжлэг авсан.



2-р үе шатанд нөлөөлөлд өртсөн өрхийн бизнес эрхлэгч 52 өрх хамрагдаж үүнээс 34 иргэн мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх богино хугацааны сургалтад сууж, 45 өрх тоног төхөөрөмжийн дэмжлэг авсан. Төслийн үр дүнд нийт 74 иргэн мэргэжлийн болон жижиг бизнес эрхлэх сургалтад хамрагдаж (Зураг 1- Сургалтын төрөл, хүний тоогоор) 65 өрх 8 төрлийн өрхийн бизнес хөгжүүлж байна.



Сургалтын төрөл, хүний тоогоор



Өрхийн бизнесийн төрөл, хувиар



Жижиг дунд үйлдвэрлэл, бизнес дэмжих зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

2019 оны жилийн эцсийн байдлаар төслийн 1-р үе шатны жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, чадваржуулах, дэд төвийн үйлдвэрлэл эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, төлөөлүүлэх зорилгоор дэд төвүүдийн иргэд, оршин суугчид, жижиг дунд бизнес эрхлэгчдийн төлөөллөөс бүрдсэн бизнесийн зөвлөлүүдийг байгуулж, чадваржуулав. Нийтдээ 29 сургалт, үйл ажиллагаа хийж, 707 иргэдийг хамрууллаа. Үүнд, дэд төвүүдийн жижиг дунд бизнес эрхлэгчдийг өрхийн санхүүгийн сургалт, бизнесээ эхэл, хэрхэн бизнесийн төсөл бичих вэ, орон нутгийн төлөвлөгөө боловсруулах сургалтуудад хамруулсан. Үүний үр дүнд, Сүхбаатар дүүргийн Бизнесийн зөвлөл нь “Долоон Буудал” нэртэй ТББ болж өргөжин Сэлбэ голын эргээр мод тарих бичил төсөл боловсруулан хэрэгжүүлсэн. Уг бичил

төслийн хүрээнд тус бизнесийн зөвлөл нь гишүүдтэйгээ хамтран 2016 онд 108, 2017 онд 227 мод тарьж, өдгөө арчлан хамгаалж байна.



2016 оноос жижиг дунд бизнесийг дэмжих үйл ажиллагаа болон бага хүүтэй зээл олгох талаар Хас банкт хамтын ажиллагааг эхлүүлж, зээлийн бүтээгдэхүүн, шаардлагуудын талаар орон нутгийн бизнес эрхлэгчдэд мэдээлэл, сургалт зохион байгуулж холбож өглөө. Энэхүү хамтын ажиллагааны үр дүнд, 2017 оны 5-р сарын байдлаар Баянхошуу дэд төвийн 266, Сэлбэ дэд төвийн 619 жижиг дунд бизнес эрхлэгчид Хас банкны жижиг

дунд бизнес эрхлэгчдэд олгодог зээлд хамрагдаж, нийт 8,073,402.313 төгрөгийн (Баянхошуу дэд төв-2,459,042,338; Сэлбэ дэд төв-5,614,359,975) зээлийг авсан байна. Үүнээс 39.7% нь үйлчилгээ, 54% нь худалдаа, 6.4% нь үйлдвэрлэлийн зориулалтаар авсан байна. Мөн 600 бичил бизнес эрхлэгчдийг сургалтад хамруулж, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвтэй холбож, бичил зээлийн мэдээлэлтэй холбож өгсөн байна.

Хөдөлмөр эрхлэлт: 2019 оны жилийн эцсийн байдлаар барилга угсралтын ажилд оролцож байгаа гүйцэтгэгч компаниудын хамтын ажиллагааны хүрээнд дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд 56 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилж, ажилтай болгохын зэрэгцээ “Ур чадварыг хөгжүүлэх нь” туршилтын төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Мөн нийгмийн барилга байгууламжийн ашиглалтын хүрээнд СХД-ийн 261-р цэцэрлэг 2018 оны 12-р сард ашиглалтад орсон бөгөөд одоогоор 345 хүүхэдтэй, 41 багш ажилчидтай үйл ажиллагаа явуулж байгаагаас Баянхошуу дэд төвийн 32 иргэнийг (80%) үндсэн ажилтнаар ажиллуулж байна. Мөн барилга угсралтын ажил явагдаж байгаа гүйцэтгэгч компаниуд дэд төвийн иргэдээс 11 иргэн тогооч, цэвэрлэгээ, засварчин, туслах ажилтан гэх мэт байнгын болон түр ажилтнаар ажилласан байна.

12-р сарын 12-ны өдөр жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийн зөвлөлдөх уулзалтыг Баянхошуу дэд төвийн Бизнес Инкубатор төвд зохион байгууллаа. Уг уулзалтад 110 хүн оролцсон бөгөөд жижиг дунд үйлдвэрлэлийн зээлд хэрхэн хамрагдах, шалгуур үзүүлэлтүүд болон бусад боломжуудын талаарх мэдээллийг авлаа. Мөн өөрсдийн тулгамдаж буй асуудлуудаа хуваалцаж, хэрхэн шийдвэрлэж болох талаар зөвлөлдлөө.

“Ур чадварыг хөгжүүлэх нь” олон улсын туршилтын төсөл (2019-2020)

Монгол Улсад дэд бүтцийн төслүүдийн ашиглагдаагүй нөөц бололцоог нээж, ажлын байран дахь дадлагажуулах сургалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Build for Skills” буюу “Ур чадварыг хөгжүүлэх” төслийг Монгол Улсын Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ), болон Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны “Улаанбаатар Хотын Гэр Хорооллыг Хөгжүүлэх, Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Хөтөлбөр” (УБХГХХХОДХ) төсөл хамтран 2019 оны 3 сараас эхлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд дараах үйл ажиллагаануудыг Баянхошуу, Сэлбэ, Дэнжийн 1000, Дамбадаржаа дэд төвүүдийн иргэдэд зохион байгуулав.

- Төслийн танилцуулга уулзалтыг 2 удаа дүүргүүдийн хөдөлмөрийн хэлтэс, халамж үйлчилгээний ерөнхий газрын төлөөлөл, хороодын засаг дарга, хэсгийн ахлагчид, хорооны нийгмийн ажилтнуудад зохион байгуулан хамтран ажилласан бөгөөд нийт 98 хүн оролцлоо.
- 5, 10-р сард Мэргэжлийн Боловсрол, Сургалтын үнэлгээний төвтэй хамтран гэр хороололд оршин суудаг, ажил амьдралын туршлага, амьдрах орчноос ур чадвар эзэмшсэн боловч мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээгүй 71 иргэнийг барилгын сантехник, бетон арматур, цахилгаан, засал чимэглэл болон гагнуурын мэргэжлээр мэргэжлийн ур чадварын үнэлгээнд оролцуулснаас 44 иргэн тэнцэж, QR кодтой, мэргэжлийн гэрчилгээтэй болов.

- Үнэлгээнд хамрагдаад, тэнцээгүй 27 иргэнийг Барилгын Политехникийн коллеж болон гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ур чадварын түвшинд нь тохируулан урт болон богино хугацааны ажлын байран дээрх мэргэшүүлэх сургалтуудад хамруулна.
- Төслийн дэд төвүүдийн инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад оролцож буй гэрээт гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагуудаас 33 ажилтныг ажлын байран дээрх дадлагажуулагч багшаар бэлтгэж, 3 компанид 35 оюутныг амжилттай уртын дадлага хийлгэв. Үүнээс 2 оюутан үндсэн ажилтнаар цаашид ажиллахаар болсон.
- Гэрчилгээжсэн болон мэргэшүүлэх сургалт төгссөн иргэдийг гэрээт гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагуудад ажлын байранд зуучлах ажиллагааг төлөвлөөд байна.




АХБ-ны Хамгааллын бодлогыг хэрэгжүүлсэн байдал

Нийгмийн хамгаалал, жендэрийн төлөвлөгөөний хэрэгжилт

Хөтөлбөрийн I үе шатны нийгмийн хамгааллын төлөвлөгөө нь нийт 17 үйл ажиллагаа, 48 шалгуур үзүүлэлттэйгээс 2019 оны 12-р сарын 20-ны байдлаар 9 үйл ажиллагааны 26 шалгуур үзүүлэлт хангагдсан ба иргэдийн уулзалтууд, мэдээлэл түгээх, иргэдийн өргөдөл гомдлыг барагдуулах, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр гэх мэт 8 үйл ажиллагаа, 22 шалгуур үзүүлэлт хэрэгжүүлэх шатанд байна. Мөн жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө 11 үйл ажиллагаа, 15 шалгуур үзүүлэлттэйгээс 8 үйл ажиллагааны 12 шалгуур үзүүлэлт хэрэгжилтийн шатандаа, 3 үйл ажиллагааны 4 шалгуур үзүүлэлт хүлээгдэж байна.

Байгаль орчин





1. Монгол улсын Байгаль орчныг холбогдох хууль, эрх зүйн нийцэл

Монгол улсын байгаль орчны холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн хөрөнгө оруулалтын 3 үе шат тус бүрд дараах баримт бичгүүдийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)-д нийцүүлэн боловсруулсан.

Мөн Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хууль, БОНХЯ-ны сайдын 2014 оны 04 дугаар сарын 10-ны А-117 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 5 жилийн зардлыг тусган боловсруулдаг ба тус Байгаль орчны менежмент төлөвлөгөө (БОМТ) нь нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан баримт бичиг бөгөөд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-ний салшгүй хэсэг юм.

“Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн Төсөл 1-ийн хүрээнд сонгогдсон Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан /БОННУ/-г “Энвайрон” ХХК 2013 онд боловсруулж, барилгажилтын шинэчилсэн зураг төслийн хүрээнд БОННУ-ний Нэмэлт тодотголыг “Грийт Вишн” ХХК 2018 онд тус тус Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)-д нийцүүлэн хийж гүйцэтгэсэн ба БОАЖЯ-аар баталгаажуулсан.

Төслийн 1-р үе шатны гүйцэтгэгчид барилгажилт эхэлсэнтэй холбогдуулан гэрээт ажлын удаах жилийн Байгаль орчны менежмент төлөвлөгөөг БОНХЯ-ны сайдын 2014 оны 04 дугаар сарын 10-ны А-117 дугаар тушаалын дагуу 12 сарын 5-наас өмнө боловсруулж Төслийн удирдах нэгжийн Байгаль орчны мэргэжилтэнд хүлээлгэн өгөх ба гүйцэтгэгчдээс ирүүлсэн тайланг нэгтгэн БОАЖЯ-ны ХБОБНУГ-аар батлуулна.

Мөн тус журмын хүрээнд гэрээт ажил гүйцэтгэсэн жилийн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний Биелэлтийн тайланг 09-р сарын 25-аас өмнө боловсруулж Төслийн удирдах нэгжийн Байгаль орчны мэргэжилтэнд хүлээлгэн өгөх үүргийг мөн адил хүлээх ба гүйцэтгэгчдээс ирүүлсэн тайланг нэгтгэн Нийслэлийн Байгаль орчны газраар батлуулан, үнэлүүлнэ. Ингэснээр тус цаашид төслийг үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

Төслийн 1-р үе шатны хүрээнд Баянхошуу дэд төвд 14 гэрээт ажил, Сэлбэ дэд төвд 16 гэрээт ажил байгаагаас 2019 оны 4-р улирлын байдлаар 10 ажил дуусаж, Улсын комисст хүлээлгэн өгч, 19 гэрээт ажил дуусаагүй, үлдсэн 1 ажлын гүйцэтгэгч хараахан шалгараагүй байна.

Гэрээт ажлын гүйцэтгэгчид хүлээсэн үүргийн дагуу 2019 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайлан, 2020 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөг тус тус боловсруулан ТУН-ийн БО-ны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.

ТУН-ийн БО-ны мэргэжилтэн БОНХЯ-ны сайдын 2014 оны 04 дугаар сарын 10-ний А-117 дугаар тушаал журмын хүрээнд боловсруулан ирүүлсэн гүйцэтгэгчдийн 2019 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайлангуудыг нэгтгэн Нийслэлийн Байгаль орчны газраар батлуулахаар 2019 оны 11-р сард хүлээлгэн өгсөн бол гүйцэтгэгчдийн 2020 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөний тайлангуудыг нэгтгэн БОАЖЯ-аар дүгнүүлэхээр 2019 оны 12-р сарын 01-нд хүргүүлсэн.

БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 тушаалын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах шинэчилсэн журмын дагуу 2020 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөний тайлангуудыг холбогдох дүрэм журмын шаардлагад нийцүүлж дахин боловсруулж 12-р сарын 10-нд БОАЖЯ-аар батлуулахаар хүргүүлээ.

2. АХБ-ны байгаль орчныг хамгаалах бодлогын зарчмын нийцэл

“Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн үе шатуудын нэгдсэн Байгаль орчны үнэлгээ, хяналтын хамрах хүрээний тайланг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /БОНБУ/ (2012), болон АХБ-ны байгаль орчныг хамгаалах бодлогын зарчим /ХБББ/-д нийцүүлэн 2013 онд боловсруулж, НЗДТГ-аар батлуулж АХБ-д хүлээлгэн өгсөн ба тус тайланг дахин 2017 оны 2-р сард шинэчилсэн.

Төсөл 1-ыг Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны зүгээс “Анхдагч байгаль орчны үнэлгээ /АБОҮ/ явуулах шаардлагатай В ангилал” хэмээн ангилсан ба төслийн АБОҮ-г АХБ-ны байгаль орчныг хамгаалах



бодлогын зарчим /ХБББ/ (2009)-д нийцүүлэн 2013 оны 10-р сард боловсруулж АХБ-нд хүлээлгэн өгсөн ба тус төслийн Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг агуулсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /БОМТ/-г мөн 2013 онд АХБ-ны зарчимд нийцүүлэн боловсруулж, 2017 оны 2-р сард дахин шинэчлэн баталсан.

Төсөл 1-ийн Байгаль орчны мониторингийн тайланг жил бүр боловсруулан АХБ-руу илгээн батлуулдаг ба 2019 оны 7-р сард Дөрөв дэх Байгаль орчны мониторингийн тайланг боловсруулан илгээсэн.

Мөн төслийн Байгаль орчны Хөндлөнгийн мониторингийн тайланг жил бүр боловсруулах шаардлагатай ба 2018 оны Байгаль орчны Хөндлөнгийн мониторингийн тайланг хийж гүйцэтгэн 2019 оны 1-р сард АХБ-руу илгээсэн.

Төслийн санхүүгийн менежмент

Хөтөлбөрийн санхүүгийн удирдлага төсвийн хөрөнгийг зохистой зарцуулах, санхүүгийн нөөцийг оновчтой хуваарилах, зээлийн хөрөнгийг хэмнэлттэй бөгөөд үр дүнтэй зарцуулах замаар мөнгөний үнэ цэнийг хамгийн сайн хүртэхийг зорилго болгоно.

Төслийн санхүүгийн удирдлага нь төслийн хөрөнгө нөөц болон зээлийн зарцуулалтыг зохистой удирдаж, хөтөлбөрийн зорилтыг биелүүлэхийн тулд төсөвлөлт, мөнгөн хөрөнгийн удирдлага, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагнал, төлбөрийн системийн дотоод хяналт, аудитын үйл ажиллагаатай уялдуулан нэгтгэх үйл явц юм. Цаг хугацаандаа бэлтгэгдсэн санхүүгийн үнэн зөв, бодит хэрэгцээтэй мэдээлэл нь хөтөлбөрийн удирдлагад зөв шийдвэр гаргах үндэс суурь болж, улмаар төслийн бодит хэрэгжилтийг эрчимжүүлж, хөрөнгө нөөцийн аюулгүй байдлыг ханган, төслийн хэрэгжилтийн хүндрэл бэрхшээлийг багасгах ач холбогдолтой. Санхүүгийн удирдлагыг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Азийн Хөгжлийн Банк, Европын Хөрөнгө Оруулалтын Банкны бодлого журам, бусад холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журамд нийцүүлэн зохион байгуулснаар улсын төсөв, зээл, тусламжийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах үндсэн нөхцөл бүрдэнэ.

Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн санхүүгийн удирдлага дээрх зорилтуудад үйлчлэх бөгөөд дараах ач холбогдол бүхий мэдээллийн системийг бүрдүүлэхэд чиглэнэ. Үүнд:

- i. Төслийг удирдах, хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэгтэй байгууллага хүмүүсийг хэрэгцээтэй мэдээллээр хангах;
- ii. Төслийн хөрөнгийг заасан зориулалтын дагуу үр дүнтэй, үр ашигтай зарцуулсныг нотлох баримт, мэдээллээр санхүүжүүлэгч талыг хангах;
- iii. Зүй бус үйлдэл, зөрчлийг цаг тухайд нь олж тогтоох чадвар, төлбөр тооцооны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлснээр аливаа залилангийн шинжтэй болзошгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх.

2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Төсөл 1-ийн АХБ-ны MON-3099 (COL) зээлийн хүрээнд 12.7 тэрбум төгрөг, MON-3098 (OCR) зээлийн хүрээнд 21.9 тэрбум төгрөг, Европын Хөрөнгө Оруулалтын Банкны FI'83097 зээлийн хүрээнд 27.4 тэрбум төгрөгийн зээлийн ашиглалт тус тус бүртгэгдсэн бөгөөд эдгээрээс зарцуулалт дараах байдалтай байна. Үүнд:

- АХБ-ны MON-3099 (COL) зээлийн эх үүсвэрээс 14.92 тэрбум төгрөг дэд төвүүдэд баригдаж буй нийгмийн байгууламжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн санхүүжилт болон зөвлөх үйлчилгээний зардалд;
- АХБ-ны MON-3098 (OCR) зээлийн эх үүсвэрээс 24.56 тэрбум төгрөг дэд төвүүдийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэлд;
- ЕХОБ FI'83097 зээлийн эх үүсвэрээс 17.87 тэрбум төгрөгийг усан сан, цэвэр, бохир усны шугам сүлжээний ажлын гүйцэтгэлд;
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулалт 17.99 тэрбум төгрөг газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговор, түүний дэмжлэг болон инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний хамтарсан санхүүжилттэй гэрээт ажлуудын НЗДТГ-ын хариуцах хөрөнгө оруулалтын ажлуудад тус тус зарцуулагдсан байна.



Төсөл 2-ийн хүрээнд АХБ-ны MON-3526 (COL) зээлийн хүрээнд 12.18 тэрбум төгрөг, MON-3525 (OCR) зээлийн хүрээнд 14.30 тэрбум төгрөгийн **ашиглалт** бүртгэгдсэн бөгөөд эдгээрээс **зарцуулалт** дараах байдалтай байна. Үүнд:

- АХБ-ны MON-3526 (COL) зээлийн эх үүсвэрээс 6.65 тэрбум төгрөг Дамбадаржаа, Дэнжийн Мянга дэд төвүүдийн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, захиалагчийн хяналт тавих, Төсөл 3-ийн ТЭЗҮ боловсруулах болон институцийн чадавхыг бэхжүүлэх, төслийн хэрэгжилтийн хүрээнд үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах чиглэлээр үзүүлж буй зөвлөх үйлчилгээний зардалд;
- АХБ-ны MON-3525 (OCR) зээлийн эх үүсвэрээс 10.77 тэрбум төгрөг Баянхошуу дэд төвд баригдаж буй дулааны шугам сүлжээ шинээр суурилуулах ажил, дэд бүтцийн шугамын дагуух хөрсний усны түвшин доошлуулах шушамын барилга угсралтын ажлын гүйцэтгэлд тус тус зарцуулагдсан байна.

Доорх хүснэгтэд 2019 оны төслийн санхүүжилтийн ашиглалт, зарцуулалтын дэлгэрэнгүй мэдээллийг харуулав.

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Зээлийн хэмжээ	Үндсэн Валют	Ашиглалт	Ашиглалтын хувь
1	АХБ MON-3099 (COL)	14,542,000.00	SDR	9,954,560.91	68.45%
2	АХБ MON-3098 (OCR)	27,500,000.00	USD	12,916,974.91	46.97%
3	АХБ MON-0380 (COL)	3,700,000.00	USD	3,698,992.00	99.97%
4	ЕХОБ FГ'83097	21,000,000.00	EUR	16,022,711.88	76.30%
5	АХБ MON-3526 (COL)	21,589,000.00	SDR	3,322,084.88	15.39%
6	АХБ MON-3525 (OCR)	37,110,000.00	USD	5,344,474.58	14.40%
7	Нийслэлийн Төсөв	33,150,000.00	USD	21,170,049.53	63.86%

№	Санхүүжилтийн эх үүсвэр	2019 оны батлагдсан төсөв	Үндсэн Валют	Зарцуулалт	Зарцуулалтын хувь
1	АХБ MON-3099 (COL)	20,000,000,000.00	төгрөг	14,928,425,148.69	74.64%
2	АХБ MON-3098 (OCR)	30,000,000,000.00		24,559,045,305.16	81.86%
3	АХБ MON-0380 Grant	2,640,585,400.00		Бүрэн хэрэгжсэн	
4	ЕХОБ FГ'83097	30,000,000,000.00		17,877,531,834.62	59.59%
5	Нийслэлийн Төсөв	18,000,000,000.00		17,990,814,009.00	99.95%
6	АХБ MON-3526 (COL)	4,000,000,000.00		6,654,853,362.90	166.37%
7	АХБ MON-3525 (OCR)	3,000,000,000.00		10,771,469,123.39	359.05%
8	ЕХОБ FГ'83873	-		-	
Нийт Дүн		107,640,585,400.00		92,782,138,783.76	86.20%



Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах үүднээс төслийн хүрээнд 2019 оны байдлаар Баянхошуу, Сэлбэ дэд төвийн иргэдэд төслийн үйл ажиллагааг танилцуулах, явцын мэдээлэл өгөх зэргээр олон удаагийн зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулж, улирал тутмын сониныг тараан ажилласан байна.

Байгууллагын цахим хуудсыг ажиллуулж мэдээллийг тогтмол шинэчлэн ажилласан бөгөөд нийгмийн сүлжээгээр төслийн үйл явц, онцлох мэдээлэл зэргийг цаг алдалгүй нийтэлж ажилласан.

Мөн төслийн үйл ажиллагааны тайланг улирлаар бэлтгэн төслийн оролцогч талуудад цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүргэхээс гадна байгууллагын цахим хуудаснаа байршуулж олон нийтэд нээлттэй мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн.

Байгууллагын цахим хуудсанд (www.ub-subcenter.mn) байрлах ил тод байдлын тухай мэдээлэл 4 үндсэн хэсгээс бүрддэг.

1. Үйл ажиллагааны ил тод байдал

Төслийн үйл ажиллагааны явцын тайлан мэдээг агуулсан хэсэг. Үүнд 2016 оноос 2018 оны жилийн эцсийн тайлангууд багтдаг. Мөн 2019 оны жилийн эцсийн тайланг 2020 оны I сард багтаан тайлангийн эцсийн хувилбарыг оруулахаар бэлтгэн ажиллаж байна.

2. Хүний нөөцийн ил тод байдал

Төслийн хүний нөөцийн холбогдолтой мэдээллүүд буюу нээлттэй ажлын байрны зарууд, анкет, дотоод журам, ажил сонгон шалгаруулах журам, ёс зүйн дүрэм зэрэг мэдээллүүдийг агуулдаг.

3. Албан хаагчдын утасны жагсаалт

Байгууллагын ажилтнуудын холбоо барих мэдээлэл, өргөдөл гомдол хариуцсан албан хаагчийн холбоо барих мэдээлэл зэргийг багтаасан болно.

4. Шилэн данс

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011), Шилэн дансны тухай хууль (2014)-ийн дагуу төслийн худалдан авах ажиллагааны болон санхүүгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст (www.shilendans.gov.mn) холбогдох мэргэжилтнүүд хугацаа алдалгүй оруулж ажиллав.

Байгууллагын мэдээллийн самбарт төслийн үйл ажиллагааны талаарх мэдээллүүдийг байршуулж, тендерийн болон нээлттэй ажлын байрны зарлал мэдээллийг тогтмол шинэчилж иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээлэл хүргэж ажиллав.

Байгууллагын хүний нөөцийн ил тод байдал

Төслийн зохицуулагчийн 2017 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 09 тоот тушаалаар батлагдсан Хүний нөөцийн бодлого, Монгол Улсын Сангийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх” журмын дагуу төслийн ажилтнуудын сонгон шалгаруулалтыг нээлттэй явуулж, өдөр тутмын сонин болон байгууллагын вэб сайтаар зарлан мэдээлдэг болно.

2019 оны байдлаар нийт 6 ажлын байрны сонгон шалгаруулалтуудыг нээлттэй зарлаж, зарын дагуу ирүүлсэн иргэдийн мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж ажиллав.

Сул орон тоонд ажилтан сонгон шалгаруулахад СЕХ-ийн шаардлагын дагуу АХБ-ны Зөвлөх сонгон шалгаруулах журмын Хувь зөвлөх сонгон шалгаруулах журмыг баримтлан сул орон тооны зарыг өдөр тутмын томоохон сонинд нийтлэх, байгууллагын цахим хуудсанд байршуулах замаар олон нийтэд мэдээлж байна. Санхүүжүүлэгч байгууллагын шаардлагын дагуу албан хаагчдыг АХБ-ны Авилга, хээл хахуулийн эсрэг бодлого журам болон Ёс зүйн баримт бичгийг танилцуулах, хэрэгжүүлэх сэдэвт сургалтад хамруулж танилцуулдаг. Эдгээр холбогдох баримт бичгийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан ба АХБ-наас шинэчлэн баталсан тухай бүрт шинэчилнэ.

ТХН-ийн үйл ажиллагаанд хамаарах холбогдох хууль, тогтоомж болон баримт бичгүүдийг цахим хуудаснаа байршуулах, мэдээллийн самбарт байршуулж, мэдээллээр хангах ажлуудыг зохион байгуулан ажиллав.

Өргөдөл гомдол шийдвэрлэлт

Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээ, нийгмийн байгууламжийн бүтээн байгуулалт явагдаж байгаатай холбогдуулан 2019 оны 12 сарын 25-ны байдлаар Өргөдөл гомдол 39 (11-Баянхошуу, 28-Сэлбэ) өргөдөл ирснээс газрын үнэлгээ, нөхөн олговортой холбоотой-20, барилгын явц-7, бүтнээр хамрагдах хүсэлтэй-1, цэцэрлэгт хүүхдээ хамруулах хүсэлт-1, газар эзэмших хүсэлт-1, тодорхойлолт авах-1, ажилд ороход туслах-1, нөхөн сэргээлттэй холбоотой 7 өргөдөл гомдол ирсэн бөгөөд бүгд хугацаандаа шийдвэрлэгдсэн.

Олон нийттэй харилцах, иргэдэд мэдээлэл хүргэх хүрээнд

- Төслийн явцын танилцуулга сониныг 2000 хувь бэлтгэн гаргаж, 3 дэд төвийн иргэдэд мэдээлэл хүргэв.
- Төслийн ерөнхий танилцуулга 5000 ширхэг брошурыг бэлтгэн гаргаж, иргэдийн уулзалтын үеэр тарааж байна.
- Төслийн явцыг харуулсан 3 видеог бэлтгэн, төслийн Фэйсбүүк хуудас болон вэбсайтаар дамжуулан иргэдэд хүргэж байна.
- Төслийн хүрээнд иргэдтэй хийгдсэн уулзалтуудын видео нэвтрүүлгүүд мөн пэйжүүдээр дамжин иргэдэд хүрч байна.
- Барилга угсралтын 5 ажил 100% дуусч, нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан.
- Төслийн Фэйсбүүк хуудас, вэбсайтын мэдээлэл тогтмол шинэчлэгдэж байгаа бөгөөд одоогоор Фэйсбүүк хуудас 16,900 гаруй дагагчтай байна.





IV. Хөтөлбөрийн II үе шат – Дамбадаржаа, Дэнжийн Мянга дэд төв

Нийгмийн барилга байгууламжууд

2019 оны жилийн эцсийн байдлаар Баянхошуу, Сэлбэ, Дэнжийн мянга, Дамбадаржаа дэд төвүүдэд баригдах цэцэрлэгийн барилгууд, Баянхошуу дэд төвд баригдах спорт цогцолбор, цэцэрлэгт хүрээлэн, Дэнжийн мянга дэд төвд төлөвлөсөн цэцэрлэгт хүрээлэн, Дамбадаржаа дэд төвд төлөвлөсөн спорт цогцолборын нарийвчилсан зураг төслийн газрын 0 түвшнээс дээрх барилгын зураг төслийг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Эдгээр барилга байгууламжуудын газрын асуудал шийдэгдээгүйн улмаас холбогдох байгууллагуудаас техникийн нөхцөл гаргуулж, эдгээр барилгуудын суурийн болон гадна шугам сүлжээний зургуудыг боловсруулах ажил зогсонги байдалд орсон. Зураг төслийн явцыг дараах хүснэгтэд үзүүлэв.

№	Барилга, Дэд төвүүд	Газрын байршил	Хийгдэж буй ажлууд
1.	Спорт Цогцолбор /Баянхошуу дэд төв/	СХД-ийн 7-р хороо, /НОБГ-ын эзэмшлийн газар/	- Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 90%-тай хийгдэж байна. - НОБГ болон ТХН-ын хооронд Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан тус газар дээр усан спорт цогцолбор барина.
2.	240-н хүүхдийн цэцэрлэгийн барилга /Баянхошуу дэд төв/	СХД-ийн 7-р хороо, /Иргэний өмчлөл/	- Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 92%-тай хийгдэж байна. - Иргэний газар тул газар болон эд хөрөнгийн үнэлгээ хийлгэж, иргэнтэй зөвшилцөх ажлыг зохион байгуулж ажиллаж байна.
3.	Олон Нийтийн Хөгжлийн төв /Баянхошуу дэд төв/	СХД-ийн 7-р хороо, /Иргэний өмчлөл/	- Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 80%-тай хийгдэж байна. - Иргэний газар тул газар болон эд хөрөнгийн үнэлгээ хийлгэж, иргэнтэй зөвшилцөх ажлыг зохион байгуулж ажиллаж байна.
4.	Цэцэрлэгт хүрээлэн /Баянхошуу дэд төв/	СХД-ийн 9-р хороо, Сонгинохайрхан уулын урд бэлд /СХД-ийн тусгай хамгаалалттай бүс/	Газрын асуудлаар НЗДТГ болон СХД-ийн удирдлагуудтай санал солилцов.
5.	Спорт Цогцолбор /Дамбадаржаа дэд төв/	СБД-ийн 16-р хороо, /Ойн хөгжлийн төвийн эзэмшил/	3.2 га талбайг тус зориулалтаар олгуулахаар ажиллаж байна. НГЗБА, НЗДТГ-аас тус байгууллагад албан хүсэлтээ хүргүүлсэн.
6.	Олон Нийтийн Хөгжлийн төв /Дамбадаржаа дэд төв/	СБД-ийн 16-р хороо, /Ойн хөгжлийн төвийн эзэмшил/	
7.	150 хүүхдийн цэцэрлэгийн барилга /Дамбадаржаа дэд төв/	Сүхбаатар дүүргийн 17-р хороо, /Иргэдийн өмчлөл/	Нийт 11 айлын газар чөлөөлөх шаардлагатай. Газар болон эд хөрөнгийн үнэлгээ хийлгэж, иргэдтэй зөвшилцөх ажлыг зохион байгуулж ажиллаж байна.
8.	240 хүүхдийн цэцэрлэгийн барилга /Дэнжийн мянга дэд төв/	Чингэлтэй дүүргийн 11-р хороо, /Бармон ХХК-ийн эзэмшил/	- Бармон ХХК-ний гэр хорооллыг дахин төлөвлөх төслийн хүрээнд хамрагдсан. Бармон ХХК-тай зөвшилцөж газрыг чөлөөлнө. - Нарийвчилсан зураг төслийг иж бүрдлээр нь Бармон ХХК-ийн урьдчилан төлөвлөсөн газарт байршлыг тооцон 100% дуусган тендерийн баримт бичгийг бэлтгэж байна.
9.	Цэцэрлэгт хүрээлэн /Дэнжийн мянга дэд төв/	Чингэлтэй дүүргийн 11-р хороо, /Бармон ХХК-ийн эзэмшил/	
10.	150 хүүхдийн цэцэрлэгийн барилга /Сэлбэ дэд төв/	СБД-ийн 14-р хороо, /Иргэдийн өмчлөл/	- Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 92%-тай хийгдэж байна. - Төсөлд оролцох сонирхолтой иргэдийн судалгаа хийгдэж байна.
11.	Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийг түр хамгаалах байр	Баянзүрх дүүрэгт, /Нийслэлийн Цагдаагийн газрын эзэмшил/	Хуульзүйн Дотоод хэргийн яам, Нийслэлийн цагдаагийн газартай хамтран газрын асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Барилга угсралтын ажлууд

Төсөл 2-ын хүрээнд төсөл 1-ийн хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн дараах ажлууд шугам сүлжээний ажлууд багтаж байгаа болно.

Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах шинэ дулааны магистраль шугамын ажил

Хүчин чадал:	Насос станцын барилга - 3х650 м3/ц хүчин чадалтай; Дулааны шугам /2ф400мм/ - 450м; Дулааны шугам /2ф500мм/ - 1900м; Дулааны шугам /2ф600мм/ - 650м; УДДТ барилга - 2ш; ХТП барилга - 2ш;
Гүйцэтгэгч:	БНСУ-ын “Жангхан Инженеринг” ХХК, “KDHEC” ХХК, болон Монгол Улсын “Одкон Холдинг” ХХК-иудын түншлэл
Гэрээний дугаар:	ВНФ06В - Ажлын явц: 85%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	- Гадна дулааны шугам, даралт өргөх насос станц, Ус дулаан дамжуулах төвийн барилга угсралт болон дулаан механикийн ажлын зураг төслүүд бүрэн дуусч магадлалаар батлагдсан. - Баглагдсан ажлын зургийн дагуу шинээр хийх гадна дулааны 2ф600мм-ийн диаметртэй 0.65 км шугам, 2ф400мм-ийн диаметртэй 0.45 км шугамын угсралтын ажил бүрэн хийгдсэн. 2ф500мм-ийн диаметртэй шугамын угсралтын ажил нийт 1.89 км шугамыг угсарч суурилуулсан. 3х650 м3/ц хүчин чадалтай насос станц 90%, ус дулаан дамжуулах төвүүдийн барилга угсралтын ажил 65%, ХТП-ийн барилга угсралтын ажил 70%-тай тус тус хийгдсэн.



Өргөлийн насос станцын барилга



Өргөлийн насос станцын дотор тоноглол



Дулааны шугамын төлөвлөлт



Сэлбэ дэд төвийн хөрсний ус зайлуулах шугам хоолойн барилга угсралтын ажил, Үе шат-1

Хүчин чадал:	Хөрсний ус зайлуулах шугам - 1305м;
Гүйцэтгэгч:	“Набсан” ХХК, “Тэргүүн Инвест” ХХК, “Тэгш Плант” ХХК-иудын түншлэл
Гэрээний дугаар:	GWD11 - Ажлын явц: 100%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	Хөрсний ус зайлуулах 1305м шугамын барилга угсралтын ажил бүрэн хийгдэж дууссан.

Сэлбэ дэд төвийн хөрсний ус зайлуулах шугам хоолойн барилга угсралтын ажил, Үе шат-2

Хүчин чадал:	Хөрсний ус зайлуулах шугам - 2260м;
Гүйцэтгэгч:	“Вайт Финикс” ХХК, “Хасу Мегаватт” ХХК, “Эвт Трак” ХХК-иудын түншлэл
Гэрээний дугаар:	GWD14 - Ажлын явц: 88%
Хийж гүйцэтгэсэн ажлууд:	Хөрсний ус зайлуулах 1979м шугамын барилга угсралтын ажил хийгдсэн.

Худалдан авах ажиллагаа

WSC16B дугаартай “Цайз эко хорооллын усан хангамж, ариутгах татуургын шугам, гадна дулаан, хэрэгцээний халуун усны шугам, болон цахилгааны холболтын зураг төсөл, угсралтын ажил”-ын тендерийн баримт бичгийг бэлтгэж, түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр 2019 оны 11-р сарын 15-ны өдөр зарласан.

Нийгмийн хамгаалал, жендэрийн төлөвлөгөөний хэрэгжилт

15 үйл ажиллагаа, 30 шалгуур үзүүлэлттэйгээс 11 үйл ажиллагаа 13 шалгуур үзүүлэлт хэрэгжилтийн шатандаа 4 үйл ажиллагааны 17 шалгуур үзүүлэлт хүлээгдэж байна.

Төслийн 2-р үе шатны Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төв, Чингэлтэй дүүргийн 14, 18, Сүхбаатар дүүргийн 13, 14-р хороодын удирдлагатай хамтын ажиллагааны санамж бичиг зурж төслийн 2-р үе шатыг амжилттай эхлүүлээ.

Дамба болон Дэнжийн мянга дэд төвийн иргэдтэй 26 удаагийн зөвлөлдөх уулзалтыг хийсэн бөгөөд нийт 853 иргэд оролцож, төслийн танилцуулга, АХБ-ны хамгааллын бодлого, газар чөлөөлөлт, өргөдөл гомдол хэрхэн гаргаж талаарх мэдээллийг авч, хэрхэн хамтран ажиллах талаар санал бодлоо солилцлоо.





V. Дүгнэлт, тулгамдаж буй асуудлууд

2019 оны байдлаар төслийн хэрэгжилтийг удаашруулах эрсдэлтэй дараах асуудлуудад байна. Үүнд:

- 1. Барилга байгууламжууд баригдах газрын асуудал:** Төсөл хэрэгжүүлэх хугацаанд газрын зөвшөөрөлтэй холбоотойгоор нарийвчилсан зураг төслийг эцэслэн, төслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хүндрэл учруулж буй асуудал нь Барилгын тухай хуулийн 4.1.8-д заасны дагуу *“барилга байгууламжийн техникийн нөхцөл гэж барилга байгууламжийг дулаан, уур, хий, цэвэр, бохир ус, цахилгаан, харилцаа холбоо, дохиолол зэрэг эх үүсвэрт холбох эрх бүхий хуулийн этгээдээс гаргах шийдвэрийг хэлнэ”* гэж, мөн 22.1-д заасны дагуу барилга байгууламжийн техникийн нөхцөл авах хүсэлтэд гаргахад хавсаргах баримт бичгүүд нь газрын зөвшөөрөл, кадастрын зураг, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, эх загвар зураг, инженерийн хангамжийн хэрэгцээг тодорхойлсон мэдээлэл зэрэг болно гэсэн заалтуудтай холбоотой. Иймд, төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бүтээн байгуулалтын томоохон төслүүд, тухайлбал шугам сүлжээ гэх мэт их хэмжээний тархсан газрыг хамарсан барилга угсралтын ажлуудын техникийн нөхцөл болон архитектур төлөвлөлтийн даалгавар зэргийг олгоход баримтлах нөхцөлийг оновчтой болгох, эрх бүхий байгууллагуудын хоорондын уялдаа холбоог удирдлагын түвшинд ханган ажиллах шаардлагатай байна.
- 2. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт:** Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн иргэдэд гэрээ байгуулснаас хойш нөхөн олговор олгогдох хүртэл олон шат дамжлага дамжин дунджаар 80 орчим хоног зарцуулж байна. Нөгөө талаас, Газрын тухай хуулийн 42.4-д зааснаар *“Хувийн гэр, орон сууцны хашааны газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тохиолдолд түүнийг чөлөөлөх ажлыг зөвхөн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хийнэ”* гэж зааснаар нөлөөлөлд өртсөн айл, өрхүүд тухайн хугацаанд газраа чөлөөлж нүүж байгаа нь барилгын ажлын талбайг гүйцэтгэгчид гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх боломжгүй байдал үүсгэн, гэрээний хугацаанд барилга угсралтын ажлыг Захиалагчийн талаас саатуулах эрсдэлийг бий болгож байна.
- 3. Төслийн санхүүжилт:** Нийслэлийн төсөвт батлагдсан 18.0 тэрбум төгрөгийн төсвөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговор болон Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд баригдаж буй авто зам, дулааны шугам сүлжээ, цэвэр бохир ус, холбооны шугам сүлжээ зэрэг инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүрээнд хамтарсан санхүүжилттэй гэрээт ажлуудын НЗДТГ-ын хариуцах хөрөнгө оруулалтын санхүүжилт 99.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Тайлант оны жилийн эцсийн байдлаар төсөл хэрэгжүүлэгч нэгжид гэрээний дагуу гүйцэтгэлээр 13.95 тэрбум төгрөгийн барилга угсралтын ажлын төлбөрийн нэхэмжлэл ирсэн бөгөөд Нийслэлийн хариуцах санхүүжилтийн 2019 онд батлагдсан төсөв хүрэлцэхгүй шалтгааны улмаас 2020 оны төсвөөс санхүүжүүлэхээр Нийслэлийн засаг даргын захирамжийн төсөлд хүлээгдэж байна.

Хавсралт 1. Хүлээлгэн өгсөн барилга угсралтын ажлууд

1. Баянхошуу дэд төвд ариутгах татуургын 1-р хэсгийн өөрийн урсгалтай зөөлөн ширмэн (3ш) хоолой бүхий ариутгах татуургын шугамын барилгын ажил /4116 м/

2. Баянхошуу дэд төвд ариутгах татуургын 2-р хэсгийн өөрийн урсгалтай зөөлөн ширмэн (3ш) хоолой бүхий ариутгах татуургын шугамын барилгын ажил

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН АКТ

2016 оны 12 сарын 4-ны өдөр Дугаар 2016/425 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 4, 5, 7, 18, 26 дугаар хороо Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн захиалгатай Баянхошуу дэд төвийн ариутгах татуургын Ф450-500мм, 4116м коллектор шугамын угсралтын ажил

1.2. Захиалагч аж ахуйн нэгж, байгууллага (Зөвлөх үйлчилгээ эрхлэгч) Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл

1.3. Ашиглагч аж ахуйн нэгж, байгууллага Ус сувгийн удирдах газар

1.4. Ерөнхий болон туслам гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллага “Бумбод” ХХК, “Алтай ренд” ХХК

1.5. Зураг төсөл боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага “Престиж Инженеринг” ХХК

1.6. Монгол Улсын Засгийн Газрын 2012 оны 151 дүгээр тогтоол шийдвэрээр зохион байгуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй улсын комисс нь уг барилга байгууламжийг ашиглалтад оруулахад бэлэн болсон тухай захиалагч байгууллагын 2016 оны 08 сарын 08-ны өдрийн 11 дугаар мэдээллийн дагуу 2016 оны 12 сарын 08-ны өдөр 08-ны өдөр багтаан шинээр барьсан, өргөтгөл, шинэтгэл, эх засварын ажлын чанар, холбогдох акт, баримтуудтай танилцаад газар дээр нь шалтга үзэв.

1.7. Энэхүү барилга байгууламжийг 2016 оны 12 сарын 08-ны өдөр барилга байгууламжийн 08 сараас барьж эхэлсэн бөгөөд 2016 оны 08 сарын 20-ны өдөр барьж дуусгасан байна.

ХОёр

2.1. Энэхүү Сонгинохайрхан дүүргийн 4, 5, 7, 18, 26 дугаар хороо Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн захиалгатай Баянхошуу дэд төвийн ариутгах татуургын Ф450-500мм, 4116м коллектор шугамын угсралтын ажил барилга байгууламж, холбогдох акт, баримтуудыг шалтгад ашиглалтад оруулах тухай комиссоос ШИЙДЭВЭРЛЭСЭН нь:

Барилгын ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

2.2. Энэхүү барилга байгууламж нь зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, зориулалтаар ашиглахад бэлэн бөгөөд гэж үзээд захиалагч (ашиглагч) байгууллага болон Ус сувгийн удирдах газар-ын мэдээлэл 2016.12.04-ны өдөрөөс ашиглалтад (үйлдвэрлэл, үйлчилгээ, оршин суух зэрэг) оруулахыг зөвшөөрөв.

2.3. Комиссоос даалгач нь: Гүйцэтгэгч байгууллагад: Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын акт, холбогдох баримтуудын аж ахуйн эрхлэл, үлдэх хувийг ашиглагч байгууллагад 1 хөнгийн дотор багтаан шалгуулах. Захиалагч (ашиглагч) байгууллагад.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2016 оны 12 сарын 23-ны өдөр Дугаар 2016/425 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 14,18 дугаар хорооны нутаг дэвсгэрт дунд төвөгшилтэй ангиллын Долоон буудал коллекторын 2183м ариутгах татуургын шугамын ажилд Засгийн газрын 69, 172 дугаар тогтоол, шийдвэрээр байгуулагдсан 13 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2017 оны 12 сарын 26-ний өдөрөөс эхлэн 1 хөнгийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзэлг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар Шифр: 25/2014

2.3. Захиалагч: Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар 9014001040 Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо Жигжиджавын гудамж, Хангард ордон 9 дэвхэр утас 11-324249 invest@ulaanbaatar.mn

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: “Хурд” ХХ 9010001054; Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, ИХ тойруу 45-р байшин Өөрийн байр, Утас: 320 697, 321 154, 320 697 Тусгай зөвшөөрлийн дугаар: 2015.05.26; БУ19 – 441/15

2.5. Барилгын ажлын Туслам гүйцэтгэгч байгууллага: “Зэст хөлөг” ХХК 9011144052; ТЗ-Дугаар № 2017/010 Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороо, Бүлгийн 19-61836 тоот, Утас: 99054583

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “Хайдро дизайн проект” ХХК 9011310071 3118-044/15 Утас: 99079769

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Ус сувгийн удирдах газар Баянхошуу дүүргийн 1 дүгээр хороо

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан

Гурав. Дүгнэлтийн хэсэг

3.1. Энэхүү дунд төвөгшилтэй ангиллын Долоон буудал коллекторын 2183м ариутгах татуургын шугамын ажил, түүний холбогдох баримт бичигт үзэлг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсөний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах боломжтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгач нь:

3. Сэлбэ дэд төвд ариутгах татуургын өөрийн урсгалтай зөөлөн ширмэн хоолой ариутгах татуургын шугамын барилга угсралтын ажил /2183 м/

4. Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажил /2,4 км/

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2017 оны 01 сарын 19-ны өдөр Дугаар 2017/235 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 7, 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт дунд төвөгшилтэй ангиллын Ф 600мм 2250м хүчин чадал бүхий ариутгах татуургын шугамын зориулалттай барилга, байгууламжид Нийслэлийн Засгийн газрын 69, 172 дугаар тогтоол, шийдвэрээр байгуулагдсан 16 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2017 оны 10 сарын 12-ны өдөрөөс эхлэн 1 хөнгийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзэлг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2016.10.20 239/2016

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар DD-55-2014-UB.BKH

2.3. Захиалагч: Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл СБД-ийн 8 дугаар хороо СТӨ-ний “Г” корпус 4 дэвхэр 99164221

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: “Бумбод” ХХК 9011029021; БУ17-330/16, СХД-ийн 18 дугаар хороо, 5 шөр Москвагийн 74

2.5. Барилгын ажлын Туслам гүйцэтгэгч байгууллага: “Ди Вай Кэ Би” ХХК 9011384136, 15/118 ЧДүүргийн 14-р хороо Хайлааст 12-236, утас 99109314

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “Престиж Инженеринг” ХХК 9011074122; 3116-678/13; СБД-ийн 8 дугаар хороо СТӨ-ний “Г” корпус 11 дэвхэр утас 88096887

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Ус сувгийн удирдах газар БЗД-ийн 4-р хороо Улаанбаатар хот Төхийн гудамж

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан

Гурав. Дүгнэлтийн хэсэг

3.1. Энэхүү дунд төвөгшилтэй ангиллын Ф 600мм 2250м хүчин чадал бүхий ариутгах татуургын шугамын зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзэлг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсөний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах боломжтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгач нь:

а) барилга байгууламжийн аж бүрэн баримт бичгийн аж хувийг эрхлэл, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, зээмшлэгч байгууллагад 1 хөнгийн дотор багтаан шалгуулах.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2017 оны 01 сарын 19-ны өдөр Дугаар 2017/235 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 9, 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан дунд төвөгшилтэй ангиллын 2.4км хүчин чадал бүхий үерийн хамгаалалтын байгууламж зориулалттай барилга, байгууламжид Засгийн газрын 69, 172 дугаар тогтоол, шийдвэрээр байгуулагдсан 11 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2018 оны 11 дугаар сарын 12-ны өдөрөөс эхлэн 1 хөнгийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзэлг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий хэсэг

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар 119/2018

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар 01/15

2.3. Захиалагч: Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл СБД-ийн 1-р хороо, Амарын гудамж, Соёлын төв өргөө утас: 70003069, www.ub-subcenter.mn Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар 9014001040/14-д 1-р хороо, Жигжиджавын гудамж, Хангард ордон, 9 дэвхэр утас: 14-324249, invest.ub.gov.mn

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: “Хангалца” ХХК 9011040076 БУ17-38/18, Чингэлтэй дүүрэг 2 дугаар хороо, Их тойруу 15, 166 байр 4 тоот, утас: 99116641, 11325293

2.5. Барилгын ажлын Туслам гүйцэтгэгч байгууллага:

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “Эм Даблюу Ти” ХХК 9011008119, 3111-292/17, БЗД-ийн 20-р хороо, Энхтайвны ерөн чөлөө, Комплекс илэртийн байр 206 тоот, утас: 99060812

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Нийслэлийн өмчийн харилцааны газар РД-2576588, ЧД-ийн 1-р хороо, Баян тойруу-3, Жигжиджавын гудамж утас: 11320248

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан

Гурав. Дүгнэлтийн хэсэг

3.1. Энэхүү дунд төвөгшилтэй 2.4км хүчин чадал бүхий үерийн хамгаалалтын байгууламж зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзэлг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсөний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.



“Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”

5. Сэлбэ дэд төвд үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралт болон ҮХС-ийн хамгаалалтын хайсны угсралт суурилуулалтын ажил /7 суваг – 5 суваг/

6. АХБ-ны буцалтгүй тусламжаар УСҮГ-ын үйл ажиллагааг сайжруулах /Ус хангамжийн үйлчилгээг сайжруулах ажил/

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2018 оны 12 сарын 05-ны өдөр Дугаар 2018/890 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 13, 14 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан дунд төвөгшилтэй ангиллын 1.26км хүчин чадал бүхий үерийн хамгаалалтын байгууламж зориулалттай барилга, байгууламжид Засгийн газрын 69, 172 дугаар тогтоол, шийдвэрээр байгуулагдсан 12 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2018 оны 11 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиглан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзэл шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий хэсэг

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар 133/2018

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар 02/15

2.3. Захиалагч: Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл СБД-ийн 1-р хороо, Амарын гудамж, Соёлын төв өргөө утас: 70003099, www.ub-subcenter.mn Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар 9014001040 ЧД-ийн 1-р хороо, Жигжиджавын гудамж, Хангарьд ордон, 9 давхар утас: 11-324249, invest.ub.gov.mn

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: “Экспресс зам” ХХК 9011034095 БУ11-917/17, Чингэлтэй дүүрэг 11 дүгээр хороо, Нуурын ЧД, ТУК-ийн байр 00 тоот утас: 99118716

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага:

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “Эм Даблюу Ти” ХХК 9011008119, 3Т11-292/17, БГД-ийн 20-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Комплекс импортын байр 206 тоот, утас: 99868812

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Нийслэлийн өмчийн харилцааны газар РД.2576589, ЧД-ийн 1-р хороо, Бага тойруу-3, Жигжиджавын гудамж утас: 11320248 Геодези, усны барилга байгууламжийн газар ОНБААТУГ

2.8. Барилга байгууламжийн төлөө байдал: Шаардлага хангасан

Гурав. Дүгнэлтийн хэсэг

3.1. Энэхүү дунд төвөгшилтэй 1.26км хүчин чадал бүхий үерийн хамгаалалтын байгууламж зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзэл шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2018 оны 12 сарын 05-ны өдөр Дугаар 2018/890 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын Нийслэлийн 8 дүүргийн нутаг дэвсгэрт хэсэгчилсэн төлбөрийн дунд төвөгшилтэй ангиллын 3 станц, 38 хуудас хамарсан хүчин чадал бүхий цэвэр усны алдагдалыг бууруулах, хяналт зориулалттай барилга, байгууламжид Засгийн газрын 69, 172 дугаар тогтоол, шийдвэрээр байгуулагдсан 7 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2018 оны 11 сарын 13-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиглан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзэл шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар 2018.03.19 8282018

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЯБ-А3-17-12

2.3. Захиалагч: Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгж 0004103 СБД-ийн 3-р хороо Амарын гудамж 2, Соёлын төв өргөө, Т.сүрүл 431 70003099 admin@ub-subcenter.mn

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: “Комфорт Интэкс” ХХК 9011054111 БУ17-1026/17 11800164, 12100313 80217 СХД-ийн 12-р хороо, 1-р үйлчилгээний төв, 70114448, comfort@comfort.mn

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага:

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “Хайдро дизайн проект” ХХК 90113100713Т18.2036/17 ХУД-ийн 15-р хороо, 4 үйлчилгээний цэвэр усны алдагдалыг бууруулах, хяналт зориулалттай барилга, байгууламжид Засгийн газрын 69, 172 дугаар тогтоол, шийдвэрээр байгуулагдсан 7 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2018 оны 11 сарын 13-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиглан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзэл шалгалт хийв.

Гурав. Дүгнэлтийн хэсэг

3.1. Энэхүү дунд төвөгшилтэй ангиллын 3 станц, 38 хуудас хамарсан хүчин чадал бүхий цэвэр усны алдагдалыг бууруулах, хяналт зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзэл шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

7. Баянхошуу дэд төвд барих 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга

8. Баянхошуу дэд төвд барих бизнес инкубатор төв, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилга

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2018 оны 12 сарын 11-ны өдөр Дугаар 2018/892 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан Өндөр төвөгшилтэй ангиллын 2 давхар 240 хүүхдийн хүчин чадал бүхий цэцэрлэгийн зориулалттай барилга, байгууламжид Засгийн газрын 2017 оны 69, 172 дугаар тогтоол, шийдвэрээр байгуулагдсан 20 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2018 оны 12 сарын 10-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиглан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзэл шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: 2018.05.01 128/2018

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар МШ-01(1)/2018

2.3. Захиалагч: Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар 9014001040; ЧД-ийн 1-р хороо Хангарьд ордон утас: 11324249

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: “Ус-Орчин” ХХК 9011013120 БУ1-38/17 ЧД 2-р хороо Их найман шарга төвийн 5-р давхар 99115635, 88112369 nsgartushba@yahoo.com

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага:

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “Мон шрифт” ХХК 9011115120 3Т11, 191/16БГД 6-р хороо 45-13 99647717, 99687717 amarsayaa@yahoo.com

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: 261 дүгээр цэцэрлэг 9670007144 0002925 СХД-ийн 8 дугаар хороо өөрийн байр утас: 99181492

2.8. Барилга байгууламжийн төлөө байдал: Шаардлага хангасан

Гурав. Дүгнэлтийн хэсэг

3.1. Энэхүү Өндөр төвөгшилтэй ангиллын 2 давхар 240 хүүхдийн хүчин чадал бүхий цэцэрлэгийн зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзэл шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийн ашиглалтад оруулах, болсонтой холбогдоогүйн захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад давгаж нь:

а) барилга байгууламжийн их бүрэн баримт бичгийн эх зүйлийг архиват, үлдэх хувийг захиалагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад /у/ хэлсний дотор багтаамж шилжүүлэх;

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2019 оны 04 сарын 14-ны өдөр Дугаар 2019/100 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан “Бизнес инкубатор үйлдвэр сургалтын төв-ийн 13 авто зоосолтой, 2 давхар, төхөөрөмж, хангамжтай 300 хүний багтаамжтай барилга, байгууламжид Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоол, шийдвэрээр байгуулагдсан 34 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2019 оны 05 сарын 24-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиглан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзэл шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар 2018.05.07 138/2018

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар МШ-02/2018

2.3. Захиалагч: Улаанбаатар гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгж Хан: Соёлын төв өргөө, 4-р давхар 411 тоот Бага тойруу, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14200, Монгол улс

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: “Томо Бюлдинг” ХХК 9011472038 БУ12-877/17 УБ, БЗД-ийн 4-р хороо, 15 хороолол, 27-47 Утас:89025481

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: “Термо энержи” ХХК 9011538143 БУ18-834/17 УБ,ХУД 3-р хороо, 18 хороолол, “Нутгийн буян руу”-ийн байр, 203 тоот, Утас:1.99110457, Утас:2.88116616

“Монцаст”ХХК 9011094059 БУ17-714/17 СХД-ийн 15-р хороо, ХХ-2/43 тоот

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “Моншрифт” ХХК 9011115120 3Т11-191/16 Чингэлтэй 5-р хороо, Их тойруу, Азрогдэдийн байр-401, утас:1.99887717, Утас:2.96680550 “Элста” ХХК

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: “Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газар” Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Бага тойруу-1 Хөвсгөл лөийн сэтг төвөр – 8/1, 3 дугаар давхар, Утас:Факс (976-11) 32-02-48

2.8. Барилга байгууламжийн төлөө байдал: Шаардлага хангасан

Гурав. Дүгнэлтийн хэсэг

3.1. Барилгын А блок нь тэнхлэгээрээ 33,0*20,7м хэмжээтэй, Б блок нь тойргийн 3/4 хэлбэртэй, гадна тойргийн урт нь 51.5м, дотор тойргийн урт 24.6м, өргөн нь 15.0м хэмжээтэй зорьцуу 2 давхар үйлдвэр сургалтын зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзэл шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

9. Улаанбаатар хотын Орос 14-р сургууль орчмын барилга байгууламжийн бохирын татуургын гол цуглуулах шугамын барилга угсралтын ажил

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2019 оны 3 сарын 16-ны өдөр Дугаар 261/2019 Улаанбаатар хот
Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын Нийслэлийн Банкзүрх дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдсан дунд төвөгшилтэй ангиллын 543 метр урттай ф400мм-ийн хүчин чадал бүхий бохирын татуургын гол цуглуулах шугамын зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоол, шийдвэрээр байгуулагдсан 8 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2019 оны 07 сарын 05-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гарчиглэсний дугаар 2019.09.06 043/2017
2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар СИК-24/2013
2.3. Захиалагч: “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл, СБД-ийн 8-р хороо СТО 415 утас:70003098 Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын газар
2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: “Модерн хас” ХХК, 9011305106, БУ18-1021/17, ХУД-ийн 3-р хороо, Сонгологийн зам 22-776 тоот, 9999 2760
2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: “Монгол Менежмент төв” ХХК
2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “Синид Инженеринг Консалтинг” ХХК 9011090014, 3719-1336/14, ЧД-ийн 4-р хороо, БХБНАУ-ийн тавин 3-р байр 01 тоот 324401
2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Ус сувгийн удирдах газар СБД-ийн 3-р хороо өөрийн байр
2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан

Гурав. Дүгнэлтийн хэсэг

3.1. Энэхүү дунд төвөгшилтэй ангиллын 543 метр урттай ф400мм-ийн хүчин чадал бүхий бохирын татуургын гол цуглуулах шугамын зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид завсан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн их бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, зээмшлэгч байгууллагад, — хоногийн дотор бэлтгэн шилжүүлэх;
б) барилга байгууламжийг ашиглалтад ашиглуулах, тохируулах хугацаанд

10. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн дугуй резервуарын барилга болон аэротанкийн бетон хийцийн шинэчлэлтийн ажил

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2019 оны 3 сарын 22-ний өдөр Дугаар 261/2019 Улаанбаатар хот
Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргэ 20-р хорооны нутаг дэвсгэрт баригдсан дунд төвөгшилтэй ангиллын Төв цэвэрлэх байгууламжийн дугуй резервуарын барилга болон аэротанкийн бетон хийцийн шинэчлэлийн ВВТРО1 дугаартай ажлыг Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоол, шийдвэрээр байгуулагдсан 19 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2019 оны 07 сарын 04-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гарчиглэсний дугаар 0003484, 069/2019
2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар 02/14
2.3. Захиалагч: Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар 9014001040 Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо Жижиджавын гудамж, Хангард ордон 9 давхар утас 11-324249 info@ulaanbaatar.mn Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл
2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: “Эс энд Эй Трейд ХХК 2629518, Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, СЭЭСХ ХХК-ий байр, 401, 402 тоот, Утас: 99118267 Тусгай зөвшөөрлийн дугаар: БУ12-122/19 Навсан ХХК 2039974: Улаанбаатар, Хан-уул дүүрэг 2 дугаар хороо, Өөрийн байр Утас: 99118974 Тусгай зөвшөөрлийн дугаар: БУ18-595/17 Тусгай зөвшөөрлийн гүйцэтгэгч байгууллага:
2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага:
2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: УХАТ ХХК
2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: УСУГ-ийн Төв Цэвэрлэх байгууламжийн алба
2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан

Гурав. Дүгнэлтийн хэсэг

3.1. Энэхүү дунд төвөгшилтэй ангиллын Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргэ 20-р хороо, Төв цэвэрлэх байгууламжийн дугуй резервуарын барилга болон аэротанкийн бетон хийцийн шинэчлэлийн ажил, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос

ДҮГНЭСЭН нь:

Энэхүү барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид завсан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

11. Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах дулааны 11и магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2019 оны 5 сарын 13-ны өдөр Дугаар 219/2019 Улаанбаатар хот
Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 6,7,8,9,10,19,28,29 дугаар хорооны нутаг дэвсгэрт өндөр төвөгшилтэй ангиллын Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах дулааны 11и магистраль шугамыг өргөтгөх шинэчлэх” ажилд Засгийн газрын 2017 оны 89, 172 дугаар тогтоол, шийдвэрээр байгуулагдсан 11 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2019 оны 09 сарын 06-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гарчиглэсний дугаар 2018/07-Д
2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар 000 09/2017
2.3. Захиалагч: Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгж 0004103. Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойрог-1, Амарын гудамж-2, Соёлын төв өргөө Г-корпус415 утас: 70003099 info@ulaanbaatar.mn Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар 9014001040 Чингэлтэй дүүргийн 1 дугаар хороо Жижиджавын гудамж, Бодь цамхаг 5 давхар утас 11-324249 info@ulaanbaatar.mn
2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: “ЧММ” ХХК 2085879, ХУД 3 дугаар хороо, Ажилчид гудамж, Өөрийн байр Утас: 99112362, 99100663 Тусгай зөвшөөрлийн дугаар: 2021.04.21 БУ11-504/16 “Эс энд Эй трейд” ХХК 2629518, ЧД, 1-р хороо, 8-1 тоот Утас: 99115257, 99110233 Тусгай зөвшөөрлийн дугаар: 2024.04.21 БУ12-112/19
2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага:
2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “Гандисс Оог” ХХК 2027232, 3719-1380/18 Чингэлтэй дүүрэг, 8 дугаар хороо, Бага тойрог, “Саян хороо” ХХ-ны байр 311 тоот Утас: 99081230, 323478 Тусгай зөвшөөрлийн дугаар: 2021.07.21 3719-1380/16
2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: “Улаанбаатар Дулааны Шугам Сүлжээ” ТӨХК
2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан

Гурав. Дүгнэлтийн хэсэг

3.1. Энэхүү өндөр төвөгшилтэй ангиллын Сонгинохайрхан дүүргийн 6,7,8,9,10,19,28,29 дугаар хороо, Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах дулааны 11и магистраль шугамыг өргөтгөх шинэчлэх” ажил түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос

12. Сэлбэ дэд төвд усан сан, насос станцын барилга угсралт болон ус хангамжийн шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажил

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2019 оны 11 сарын 22-ны өдөр Дугаар 2045/2019 Улаанбаатар хот
Нэг. Удиртгал хэсэг

